



**ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**  
Судалгаа, сургалт, мэдээлэл



# **ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

Захиалагч: Хууль зүйн  
үндэсний хүрээлэн

Гүйцэтгэгч:  
“Өмгөөллийн ивээл баг”  
хуулийн нөхөрлөл

Улаанбаатар хот,  
2021 он

## **АГУУЛГА**

|                                                                 |          |
|-----------------------------------------------------------------|----------|
| <b>УДИРТГАЛ</b>                                                 | 3        |
| <b>НЭГ.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ<br/>ЗАРДЛЫН ТООЦОО</b> | 3-11     |
| 1.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох                 | <b>2</b> |
| 1.2.Хуулийн этгээдийн захиргааны зардлыг тооцох                 |          |
| 1.3.Тоон үзүүлэлтийг тооцох                                     |          |
| 1.4.Нийт зардлын дүнг тооцох                                    |          |
| 1.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах             |          |
| 1.6.Нэмэлт зардлыг тооцох                                       |          |
| <b>ХОЁР.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ, АЧААЛЛЫН ТООЦОО</b>                | 11-16    |
| 2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох                           |          |
| 2.2.Иргэнд үүсэх зардал, ачааллыг тооцох                        |          |
| 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох                                     |          |
| 2.4.Нийт зардал, ачааллын дүнг тооцох                           |          |
| 2.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах             |          |
| <b>ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО</b>                 | 16-40    |
| 3.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тогтоох               |          |
| 3.2.Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох         |          |
| 3.3.Гарах зардлыг тооцох                                        |          |
| 3.4.Нийт зардлын дүнг тооцох                                    |          |
| 3.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах                     |          |
| <b>САНАЛ ЗӨВЛӨМЖ</b>                                            | 40-41    |
| <b>АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ</b>                                     | 42-43    |

# **ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

## **Удиртгал**

Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга /төсөл/-ыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар хийлээ.<sup>1</sup>

3

Энэхүү зардлын тооцоогоор “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга /төсөл/” хэрэгжиж эхэлснээр хуулийн этгээд, хувь хүн, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг урьдчилан гаргах зорилготой.

“Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга /төсөл/” хэрэгжсэнээр хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллага гэсэн гурван субъектэд нэмэлт зардал, ачаалал үүсч болзошгүй байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтад тусгагдсан үүргийг тодорхойлох, улмаар үүргийг хэрэгжүүлэх төрийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүнд үүсэх нэмэлт зардлыг урьдчилан тооцох, мөн эдгээр субъектэд үүсэх нэмэлт зардал, ачааллыг бууруулах гарцыг судлан, боломжит хувилбарыг санал болгохыг зорьсон.

## **Нэг.Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлын тооцоо**

Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу дараах зургаан үе шатаар тооцно:

- 1.Үүргийг тогтоох;
- 2.Зардал тооцох;
- 3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 4.Зардлын дүнг тооцож гаргах;
- 5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах;
- 6.Нэмэлт зардал тооцох.

### **1.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын 2.3-т “Гүйцэтгэх үүрэг гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ. Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмжлэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүргүүд хамаарна” гэжээ. Хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдэд эрх зүйн зохицуулалтаар тусгасан үүрэг нэг бүрийг энэхүү үе шатанд тогтоох зорилттой тул хуулийн этгээдээс төрийн байгууллага, гуравдагч этгээдтэй харилцах харилцаанд үүсэх үүргээс гадна хуулийн этгээдийн захиргааны шинжтэй дотоод үүргийг мөн авч үзлээ.

<sup>1</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2021.10.18-ны өдрийн төсөлд үндэслэн зардлын тооцоонд өөрчлөлт оруулан гүйцэтгэв.

| Д/д                                                                                      | Хуулийн төсөл дэх<br>холбогдох зохицуулалт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Үүргийг<br>хэрэгжүүлэх<br>байгууллага              | Гүйцэтгэх<br>үүрэг                                                                       |
|------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|
| Хоёрдугаар бүлэг.Хяналт шалгалтын үйл ажиллагаа                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                    |                                                                                          |
| 1.                                                                                       | 16.1.Улсын байцаагч бодит нөхцөл, байдлыг тогтооход хамааралтай, ач холбогдол бүхий баримт бичиг, мэдээллийг шалгуулагч этгээд болон холбогдох бусад этгээдээс үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах эрхтэй.<br>33.1.Улсын байцаагч хяналт шалгалт хэрэгжүүлэхдээ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>33.1.3.цахим болон цаасан суурьтай баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, үнэ төлбөргүйгээр гаргуулан авах;<br>38.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хяналт шалгалттай холбоотой дараах үүргийг хүлээнэ:<br>38.1.4.улсын байцаагчаас шаардсаны дагуу хяналт шалгалтад шаардлагатай баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх; | Шалгуулагч<br>этгээд,<br>холбогдох<br>бусад этгээд | Улсын байцаагчид цахим болон цаасан суурьтай баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх        |
| 2.                                                                                       | 17.1.Улсын байцаагч бодит нөхцөл, байдлыг тогтоох зорилгоор шалгуулагч этгээд болон бусад холбогдох этгээдээс тайлбар авах эрхтэй.<br>17.2.Тайлбарыг биечлэн эсхүл бичгээр авч болно. Тайлбарыг биечлэн авах тохиолдолд тодорхой асуулт тавьж, хариулт авах хэлбэрээр гүйцэтгэнэ.<br>33.1.4.тайлбар авах;                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                    | Тайлбар өгөх:<br>-Биечлэн тайлбар өгөхөд асуултад хариулт өгөх;<br>-Бичгээр тайлбар өгөх |
| 3.                                                                                       | 22.2.Улсын байцаагч шалгалтын тэмдэглэлийн хувийг шалгуулагч этгээдэд өгнө. Шалгуулагч этгээд тэмдэглэлтэй танилцсан тухай гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв гарын үсэг зурахаас татгалзсан бол улсын байцаагч энэ тухай тэмдэглэлд тусгана.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Шалгуулагч<br>этгээд                               | Шалгуулагч этгээд тэмдэглэлтэй танилцах, гарын үсэг зурж баталгаажуулах                  |
| 4.                                                                                       | 25.3.Улсын байцаагчаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хэрхэн хангасан талаар шалгуулагч этгээдээс ирүүлсэн хариуг үндэслэн гүйцэтгэлийн шалгалт хийх эсэхийг ажлын таван өдрийн дотор шийдвэрлэнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                    | Албан шаардлагын биелэлтийг хангасан талаарх хариуг хүргүүлэх                            |
| Дөрөвдүгээр бүлэг.Хяналт шалгалтын талаарх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                    |                                                                                          |
| 5.                                                                                       | 38.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хяналт шалгалттай холбоотой дараах үүргийг хүлээнэ:<br>38.1.1.үйл ажиллагаандаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандартаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлэх, эрсдэлийг бууруулах дотоод хяналт шалгалтын журмыг батлан мөрдөх;<br>39.4.Дотоод хяналтын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:<br>39.4.1.энэ хуулийн 39.3-т заасан журмыг үндэслэн үйл ажиллагаандаа мөрдөх дотоодын хяналт шалгалт хийх журмыг баталж мөрдүүлэх;                                                                                               | Аж ахуйн<br>нэгж,<br>байгууллага                   | Дотоодын хяналт шалгалт хийх журмыг батлах                                               |

|    |                                                                                                                                                      |  |                                                          |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|----------------------------------------------------------|
| 6. | 39.4.2.үйл ажиллагаандаа эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлтэй цэгийг тогтоох;                                                                           |  | Эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлтэй цэгийг тогтоох         |
| 7. | 39.4.4.хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх;                                                                                                      |  | Хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх                  |
| 8. | 39.4.5.аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын талаар ажилтнууддаа сургалт явуулах, мэдээллээр хангах; |  | Сургалт явуулж, мэдээллээр хангах                        |
| 9. | 39.4.6.дотоод хяналтын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх                                                                                      |  | Дотоод хяналтын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх |

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр шалгуулагч этгээдэд шалгалтын талаар дөрвөн үүрэг, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалтын талаар таван үүргийг хүлээлгэжээ. Шалгуулагч этгээд гэдэгт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэн аль нь байж болно.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр шалгуулагч этгээдэд хүлээлгэсэн дээрх үүргийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн хяналт шалгалтын тухай хуультай харьцуулан үзье.

| Д/д                                                    | Хуулиар хүлээлгэсэн үүрэг                                                         | ТХШТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл | Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа ТХШТХ                 | Тайлбар                                                                                     |
|--------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------|---------------------------------------|----------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хоёрдугаар бүлэг.Хяналт шалгалтын үйл ажиллагаа</b> |                                                                                   |                                       |                                                          |                                                                                             |
| 1.                                                     | Улсын байцаагчид цахим болон цаасан суурьтай баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх | 16.1, 33.1.3, 38.1.4                  | 10.9.4 <sup>2</sup>                                      | Зарчмын өөрчлөлт ороогүй. Цахим суурьтай гэж агуулгыг тодруулсан.                           |
| 2.                                                     | Тайлбар өгөх                                                                      | 17.1, 17.2, 33.1.4                    | 10.9.4                                                   | Зарчмын өөрчлөлт ороогүй. Тайлбар авах хэлбэрийг “биечлэн болон бичгээр” хэмээн тодруулсан. |
| 3.                                                     | Тэмдэглэлтэй танилцах, гарын үсэг зурж баталгаажуулах                             | 22.2                                  | 5.10 <sup>3</sup>                                        | Өөрчлөлт ороогүй.                                                                           |
| 4.                                                     | Албан шаардлагын биелэлтийг хангасан                                              | 25.3                                  | 53 дугаар зүйл.Гүйцэтгэлийн шалгалт <sup>4</sup> , 13.25 | Зарчмын өөрчлөлт ороогүй.                                                                   |

<sup>2</sup> ТХШТХ-ийн 10.9.4-т “Мэргэжлийн хяналтын улсын байцаагч хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах эрхтэй” хэмээн заасан.

<sup>3</sup> ТХШТХ-ийн 5.10-т “Шалгуулагч этгээд шалгалтын тэмдэглэлтэй танилцаж гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай шалгалтын тэмдэглэлд тусгана.” хэмээн заасан.

<sup>4</sup> ТХШТХ-ийн 5<sup>3</sup>.1-д “Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хяналт шалгалтын байгууллагаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор явуулна.” гэж, 5<sup>3</sup>.2- “Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагын хүрээнд хийнэ.” гэж, 5<sup>3</sup>.3-т “Гүйцэтгэлийн шалгалт хийхдээ шалгуулагч этгээдэд ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.” хэмээн тус тус хуульчилсан.

<sup>5</sup> ТХШТХ-ийн 13.2-т “Байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан нь хяналт шалгалтын ажилд дэмжлэг тусалцаа үзүүлж, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хяналт шалгалтын явцад илэрсэн

|                                                                                                 |                                                          |                             |              |                                                                                                                                           |
|-------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------|-----------------------------|--------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                 | талаарх хариуг хүргүүлэх                                 |                             |              | Шаардлагыг биелүүлж, дүнг тогтоосон хугацаанд албан ёсоор мэдэгдэх гэснийг “албан шаардлагын биелэлтийг хангасан хариу” хэмээн өөрчилсөн. |
| <b>Дөрөвдүгээр бүлэг.Хяналт шалгалтын талаарх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг</b> |                                                          |                             |              |                                                                                                                                           |
| 5.                                                                                              | Дотоодын хяналт шалгалт хийх журмыг батлах               | 38.1, 38.1.1, 39.4, 39.4.1, | 6.4.6, 13.17 | Өөрчлөлт ороогүй.                                                                                                                         |
| 6.                                                                                              | Эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлтэй цэгийг тогтоох         | 39.4.2                      | ---          | Шинээр нэмэгдсэн                                                                                                                          |
| 7.                                                                                              | Хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх                  | 39.4.4                      | ---          | Шинээр нэмэгдсэн                                                                                                                          |
| 8.                                                                                              | Сургалт явуулж, мэдээллээр хангах                        | 39.4.5                      | ---          | Шинээр нэмэгдсэн                                                                                                                          |
| 9.                                                                                              | Дотоод хяналтын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх | 39.4.6                      | ---          | Шинээр нэмэгдсэн                                                                                                                          |

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр шалгуулагч хуулийн этгээдэд хүлээлгэсэн есөн үүргээс тав нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн хяналт шалгалтын тухай хуульд тусгагдсан үүрэг бөгөөд дөрөв нь шинээр нэмэгдсэн үүрэг болно. Эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлтэй цэгийг тогтоох, хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх, сургалт явуулж, мэдээллээр хангах, дотоод хяналтын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх гэсэн дөрвөн үүрэг нь төрийн байгууллага, гуравдагч этгээдэд хүргүүлэхтэй холбоотой үүрэг биш бөгөөд байгууллага дотооддоо хийж хэрэгжүүлэх үүрэг юм.

## 1.2.Хуулийн этгээдийн захиргааны зардлыг тооцох

Хуулийн этгээдийн захиргааны зардлыг тооцохын тулд дээрх үүргийг гүйцэтгэхэд хийгдэх стандарт ажиллагааг юуны өмнө тодорхойлох шаардлагатай. “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын 2.3-т “Гүйцэтгэх үүрэг гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг **төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг** хэлнэ. Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмжлэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүргүүд хамаарна” гэж заасан. Хуулийн этгээдэд шинээр нэмэгдэж байгаа дараах үүрэг буюу эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлтэй цэгийг тогтоох, хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх, сургалт явуулж, мэдээллээр хангах, дотоод хяналтын үйл

зөрчил, дутагдлыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, холбогдох арга хэмжээ авах талаар тавьсан шаардлагыг биелүүлж, дүнг тогтоосон хугацаанд нь албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.” гэжээ.

<sup>6</sup> ТХШТХ-ийн 6.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг Засгийн газар тогтооно.” гэж заасан.

<sup>7</sup> ТХШТХ-ийн 13.1-д “Байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллага, тухайн Хурал, Засаг даргын болон өөрийн шийдвэрийг байгууллагынхаа хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн дотоодын хяналт шалгалтын журам тогтоож ажиллана.” гэж заасан.

ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх гэсэн дөрвөн үүрэг нь аргачлалын дагуу төрийн байгууллага, гуравдагч этгээдэд гүйцэтгэх, хүргүүлэх үүрэгт хамаарахгүй. Иймд эдгээр үүргийг хэрэгжүүлснээс үүсэх захиргааны зардлыг тооцох шаардлагагүй болно. Харин нэмэлт зардал тооцох хэсэгт эдгээр дөрвөн үүргийг хэрэгжүүлснээс хуулийн этгээдэд үүсэх зардлыг авч үзнэ.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр хуулийн этгээдэд шинээр үүрэг үүсгээгүй тул захиргааны нэмэлт зардлыг тооцох шаардлагагүй байна.

### **1.3.Тоон үзүүлэлтийг тооцох**

Тоон үзүүлэлтийг тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлэн тооцдог. Тодруулбал: энэ үе шатанд тухайн үүргийг гүйцэтгэх хуулийн этгээд болон нэг жилд гүйцэтгэх давтамжийн тоог тооцдог. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр хуулийн этгээдэд шинээр үүрэг үүсгээгүй тул тоон үзүүлэлтийг тооцох шаардлагагүй байна.

### **1.4.Нийт зардлын дүнг тооцох**

Хуулийн этгээдэд шинээр үүрэг үүсгээгүй тул нэмэгдэх зардал байхгүй. Хуулийн этгээдээс гардаг захиргааны зардал мөн хэмжээгээр гарна.

### **1.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах**

Энэ үе шатанд үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, хуулийн этгээдэд үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломж байгаа эсэхийг шалгана. Хуулийн этгээдэд шинээр үүрэг үүсгээгүй тул зардлыг бууруулах, хуулийн этгээдэд үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломж байгаа эсэхийг шалгах шаардлага байхгүй болно.

### **1.6.Нэмэлт зардлыг тооцох**

Энэ үе шатанд үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч болох нэмэлт зардлыг тооцно. Нэмэлт зардлыг тооцоход ашиглах арга, томьёо байхгүй тул аргачлалд заасан зардал тооцох аргыг хэрэглэнэ.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн дөрөвдүгээр бүлэгт хяналт шалгалтын талаарх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг тусгасан. Эдгээр үүргээс аж ахуйн нэгж, байгууллагад шинээр хүлээлгэсэн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлтэй цэгээ тогтоох, ажилтнуудад сургалт, мэдээлэл өгөх, хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх, дотоод хяналтын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх гэсэн дөрвөн үүрэг нь хуулийн этгээдэд захиргааны зардал үүсгэхээр байна.

Иймд дээр дурдсан дөрвөн үүргийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдэд үүсэх зардлыг дараах байдлаар тооцов.

- үүргийг гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх стандарт ажиллагааг тодорхойлов;
- стандарт ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг мэргэжлийн хяналтын байгууллагаар үйлчлүүлж байсан долоон хуулийн этгээдээс авсан судалгаанд үндэслэн гаргав;
- ажлын хөлсийг доор дурдсанаар тооцов.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсдын сарын дундаж цалин 2018 оноос хойш улсын хэмжээнд нэг сая төгрөг, түүнээс дээш хэмжээтэй байна.<sup>8</sup>

<sup>8</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, [www.1212.mn](http://www.1212.mn)

| Ажиллагсдын<br>цалин хөлс | 2018<br>он | 2019<br>он | 2020<br>он | Дундаж    |
|---------------------------|------------|------------|------------|-----------|
|                           | (төгрөг)   |            |            |           |
| Улсын дундаж              | 1,002,900  | 1,124,300  | 1,220,600  | 1,115,933 |

Дээрх хүснэгтээс харахад ажиллагсдын сарын дундаж цалин 100 орчим мянган төгрөгөөр нэмэгдсэн байх бөгөөд сүүлийн гурван жилийн дундаж цалин 1,115,933 төгрөг байна. Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ажилтны долоо хоногийн ажлын цаг 40 хүртэл тул ажилтан сард ажлын 22 өдөр буюу нийт 176 цаг ажиллана.<sup>9</sup>

8

| Үндсэн цалин | Ажиллах хугацаа                  | Ажлын хөлс       |
|--------------|----------------------------------|------------------|
| 1,115,933    | 176 цаг                          | 6,340.53 төг/цаг |
| 1,115,933    | 10,560 минут<br>(176 х 60 минут) | 105.67 төг/мин   |

Ажилтны сарын дундаж цалинг сард ажиллах цагт тооцож үзвэл 6,340.53 төгрөг, сард ажиллах минутад тооцож үзвэл 105.67 төгрөг болно.

| Д/д                                                                                              | Хуулийн төсөл дэх<br>холбогдох<br>зохицуулалт            | Стандарт<br>үйл ажиллагаа                                          | Зарцуулах<br>хугацаа<br>(минут) | Ажлын<br>хөлс<br>(төгрөг) | Зардал<br>(төгрөг) |
|--------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------|--------------------------------------------------------------------|---------------------------------|---------------------------|--------------------|
| <b>Дөрөвдүгээр бүлэг. Хяналт шалгалтын талаарх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг</b> |                                                          |                                                                    |                                 |                           |                    |
| 1.                                                                                               | Эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлтэй цэгийг тогтоох         | 1. Эрсдэлийн үнэлгээ хийх талаар мэдлэг мэдээлэл олж авах          | 240                             | 105.67                    | 25361              |
|                                                                                                  |                                                          | 2. Асуудлыг тодорхойлох                                            | 180                             | 105.67                    | 19021              |
|                                                                                                  |                                                          | 3. Нөхцөл байдлыг тодорхойлох                                      | 120                             | 105.67                    | 12680              |
|                                                                                                  |                                                          | 4. Эрсдэлийг тодорхойлох                                           | 360                             | 105.67                    | 38041              |
|                                                                                                  |                                                          | 5. Эрсдэлийг үнэлэх                                                | 360                             | 105.67                    | 38041              |
|                                                                                                  |                                                          | 6. Эрсдэлтэй цэгийг тогтоох                                        | 360                             | 105.67                    | 38041              |
| 2.                                                                                               | Хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх                  | 1. Хяналт тавьсан тухай бүр бүртгэлд зохих мэдээллийг бүрэн тусгах | 120                             | 105.67                    | 12680              |
| 3.                                                                                               | Ажилтнуудад сургалт явуулах, мэдээллээр хангах           | 1. Ажилтнуудад сургалт зохион байгуулах                            | 120                             | 105.67                    | 12680              |
|                                                                                                  |                                                          | 2. Ажилтнуудад хүргэх мэдээлэл боловсруулах                        | 180                             | 105.67                    | 19021              |
|                                                                                                  |                                                          | 3. Ажилтнуудад мэдээлэл хүргэх                                     | 120                             | 105.67                    | 12680              |
| 4.                                                                                               | Дотоод хяналтын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх | 1. Мэдээллийн цахим санг үүсгэх                                    | 480                             | 105.67                    | 50722              |
|                                                                                                  |                                                          | 2. Мэдээллийн цахим санд баяжилт тухай бүр хийх                    | 120                             | 105.67                    | 12680              |
|                                                                                                  |                                                          | <b>ДҮН</b>                                                         |                                 |                           | <b>291,649</b>     |

<sup>9</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 70.1-д “Долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна” гэж; 2022.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 84.1-д “Долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байна” гэж заасан.




Хуулиар хүлээлгэсэн дээр дурдсан дөрвөн үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдээс 291,649 төгрөгийн захиргааны зардал гарахаар байна.

2020.10.01-ний өдрийн байдлаар Монгол Улсад 220,002 хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлтэй байна<sup>10</sup>. 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар Монгол Улсад бизнес регистртэй ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг компани, хоршоо, нөхөрлөл, төрийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 78457 байна.<sup>11</sup>

| Д/д | Хуулийн этгээдийн төрөл | 2020 оны IV улирал | 2021 оны II улирал |
|-----|-------------------------|--------------------|--------------------|
| 1.  | Компани                 | 73253              | 71923              |
| 2.  | Хоршоо                  | 2379               | 2127               |
| 3.  | Нөхөрлөл                | 2442               | 2227               |
| 4.  | ТӨҮГ, ОНӨҮГ             | 382                | 393                |
| 5.  | <b>Дүн</b>              | <b>78457</b>       | <b>76670</b>       |

9

Татвар төлөгчөөр бүртгэлтэй 191 орчим мянган хуулийн этгээдээс татварын тайлан гаргадаг 100 гаруй мянган хуулийн этгээд, үүнээс ашигтай ажилладаг нь 50 орчим мянган хуулийн этгээд байна.<sup>12</sup> 2020 онд дэлхий нийтийг хамран тархсан Коронавируст цар тахлын халдварын нөлөөгөөр “х” тайлан гаргадаг аж ахуйн нэгжийн тоо 2 дахин нэмэгджээ.



Ашигтай ажилласан татварын тайлан гаргадаг аж ахуйн нэгжийн тоо сүүлийн 3 жилийн дунджаар 50.9 мянга байна. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр хуулийн этгээдэд хүлээлгэсэн дотоод хяналт шалгалтын журам батлах, эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлтэй цэгийг тогтоох, хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх, сургалт хийх, мэдээллээр хангах, дотоод хяналтын талаар мэдээллийн сан үүсгэх үүргийг гүйцэтгэх хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа явуулан, ашигтай ажиллаж байгаа 50.9 мянган хуулийн этгээд болно.

Эрсдэлийн үнэлгээ хийлгэх, дотоод хяналтын талаар мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг хуулийн этгээдэд шинээр үүсч байгаа үүрэг нь байнга, давтан хийгдэх үүрэг бөгөөд хууль, холбогдох журамд өөрчлөлт орох хүртэл тогтвортой үйлчилнэ. Иймд эдгээр үүргийг нэг жилд нэг удаа хийнэ хэмээн тооцвол давтамж нь 1 болно.

<sup>10</sup> Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудас, <https://burtgel.gov.mn/home>

<sup>11</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 1212

<sup>12</sup> Татварын ерөнхий газрын цахим хуудас, [www.mta.mn](http://www.mta.mn)

| Д/д                                                                                             | Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт                  | Стандарт үйл ажиллагаа                                            | Тохиолдлын тоо | Давтамж | Тоон үзүүлэлт |
|-------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------|-------------------------------------------------------------------|----------------|---------|---------------|
| <b>Дөрөвдүгээр бүлэг.Хяналт шалгалтын талаарх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг</b> |                                                          |                                                                   |                |         |               |
| 1.                                                                                              | Эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлтэй цэгийг тогтоох         | 1.Эрсдэлийн үнэлгээ хийх талаар мэдлэг мэдээлэл олж авах          | 50900          | 1       | 50900         |
|                                                                                                 |                                                          | 2.Асуудлыг тодорхойлох                                            | 50900          | 1       | 50900         |
|                                                                                                 |                                                          | 3.Нөхцөл байдлыг тодорхойлох                                      | 50900          | 1       | 50900         |
|                                                                                                 |                                                          | 4.Эрсдэлийг тодорхойлох                                           | 50900          | 1       | 50900         |
|                                                                                                 |                                                          | 5.Эрсдэлийг үнэлэх                                                | 50900          | 1       | 50900         |
|                                                                                                 |                                                          | 6.Эрсдэлтэй цэгийг тогтоох                                        | 50900          | 1       | 50900         |
| 2.                                                                                              | Хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх                  | 1.Хяналт тавьсан тухай бүр бүртгэлд зохих мэдээллийг бүрэн тусгах | 50900          | 1       | 50900         |
| 3.                                                                                              | Ажилтнуудад сургалт явуулах, мэдээллээр хангах           | 1.Ажилтнуудад сургалт зохион байгуулах                            | 50900          | 1       | 50900         |
|                                                                                                 |                                                          | 2.Ажилтнуудад хүргэх мэдээлэл боловсруулах                        | 50900          | 1       | 50900         |
|                                                                                                 |                                                          | 3.Ажилтнуудад мэдээлэл хүргэх                                     | 50900          | 1       | 50900         |
| 4.                                                                                              | Дотоод хяналтын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх | 1.Мэдээллийн цахим санг үүсгэх                                    | 50900          | 1       | 50900         |
|                                                                                                 |                                                          | 2.Мэдээллийн цахим санд баяжилт тухай бүр хийх                    | 50900          | 1       | 50900         |

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр хуулийн этгээд, аж ахуйн нэгжид хүлээлгэсэн үүрэг, стандарт үйл ажиллагааны нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлтээр үржүүлэн нийт зардлыг гаргана.

| Д/д                                                                                             | Хуулийн төсөл дэх зохицуулалт                    | Стандарт үйл ажиллагаа                                            | Тоон үзүүлэлт | Нэг бүрийн зардал (төгрөг) | Нийт зардал (мян.төг) |
|-------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------|-------------------------------------------------------------------|---------------|----------------------------|-----------------------|
| <b>Дөрөвдүгээр бүлэг.Хяналт шалгалтын талаарх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг</b> |                                                  |                                                                   |               |                            |                       |
| 1.                                                                                              | Эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлтэй цэгийг тогтоох | 1.Эрсдэлийн үнэлгээ хийх талаар мэдлэг мэдээлэл олж авах          | 50900         | 25361                      | 1,290,875             |
|                                                                                                 |                                                  | 2.Асуудлыг тодорхойлох                                            | 50900         | 19021                      | 968,169               |
|                                                                                                 |                                                  | 3.Нөхцөл байдлыг тодорхойлох                                      | 50900         | 12680                      | 645,412               |
|                                                                                                 |                                                  | 4.Эрсдэлийг тодорхойлох                                           | 50900         | 38041                      | 1,936,287             |
|                                                                                                 |                                                  | 5.Эрсдэлийг үнэлэх                                                | 50900         | 38041                      | 1936287               |
|                                                                                                 |                                                  | 6.Эрсдэлтэй цэгийг тогтоох                                        | 50900         | 38041                      | 1,936,287             |
| 2.                                                                                              | Хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх          | 1.Хяналт тавьсан тухай бүр бүртгэлд зохих мэдээллийг бүрэн тусгах | 50900         | 12680                      | 645,412               |
| 3.                                                                                              |                                                  | 1.Ажилтнуудад сургалт зохион байгуулах                            | 50900         | 12680                      | 645,412               |

|    |                                                          |                                                |       |                |                   |
|----|----------------------------------------------------------|------------------------------------------------|-------|----------------|-------------------|
| 4. | Ажилтнуудад сургалт явуулах, мэдээллээр хангах           | 2.Ажилтнуудад хүргэх мэдээлэл боловсруулах     | 50900 | 19021          | 968,169           |
|    |                                                          | 3.Ажилтнуудад мэдээлэл хүргэх                  | 50900 | 12680          | 645,412           |
|    |                                                          | 1.Мэдээллийн цахим санг үүсгэх                 | 50900 | 50722          | 2,581,750         |
|    | Дотоод хяналтын үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх | 2.Мэдээллийн цахим санд баяжилт тухай бүр хийх | 50900 | 12680          | 645,412           |
|    |                                                          | <b>ДҮН</b>                                     |       | <b>291,649</b> | <b>14,844,883</b> |
|    |                                                          |                                                |       |                |                   |

Эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлтэй цэгийг тогтоох, хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх, ажилтнуудад сургалт мэдээлэл явуулах, мэдээллийн сан бүрдүүлэх үүргийг гүйцэтгэхэд 50900 хуулийн этгээдээс 14.8 тэрбум төгрөгийн нэмэлт зардал гарна.

Хуулийн этгээдэд үүсэх зардал нь нийт зардал, нэмэлт зардлаас бүрдэнэ.

| Нийт зардал  | Нэмэлт зардал | Хуулийн этгээдэд үүсэх зардал |
|--------------|---------------|-------------------------------|
| (мян.төгрөг) |               |                               |
| ---          | 14,844,883    | 14,844,883                    |

Эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлтэй цэгийг тогтоох, хяналт тавьсан тухай бүр бүртгэл хөтлөх, ажилтнуудад сургалт мэдээлэл явуулах, мэдээллийн сан бүрдүүлэх үүргийг гүйцэтгэх нэмэлт үүргийг хэрэгжүүлэхэд 50900 хуулийн этгээдээс нийт 14.8 тэрбум төгрөгийн; нэг хуулийн этгээдээс 291,649 төгрөгийн нэмэлт зардал гарах урьдчилсан тооцоо гарч байна.

**Нэг хуулийн этгээдэд үүсэх нэмэлт зардлын урьдчилсан тооцоо:**  
**291,649 (хоёр зуун ерэн нэгэн мянга зургаан зуун дөчин есөн) төгрөг**

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 46 дугаар зүйлд эрсдэлийн удирдлагын талаар дараах байдлаар заасан болно:

-46.1-д “Мэргэжлийн хяналтын байгууллага нь хяналт шалгалтын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын зарчмыг баримтална.”;

-46.2-т “Мэргэжлийн хяналтын төв байгууллага энэ хуулийн 46.3-т заасан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг батална.”;

-46.3-т “Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны эрсдэлийг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгмийн аюулгүй байдалд учруулж болзошгүй аюул болон түүний хэмжээ, хамрах цар хүрээ, үр дагаврыг харгалзан энэ хуулийн 36.6-д заасан шалгуураар үнэлнэ” хэмээн. Энэ нь хуулийн этгээдийн хяналт шалгалтад хамрагдах тохиолдол, нөхцөл, давтамжийг бууруулах, хүндрэл чирэгдлийг багасгахад чиглэсэн зохицуулалт болжээ.

#### **Хоёр.Иргэнд үүсэх зардал, ачааллын тооцоо**

Иргэнд үүсэх зардал, ачааллыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу дараах таван үе шатаар тооцно:

- 1.Үүргийг тогтоох;
- 2.Хугацаа, зардал тооцох;
- 3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 4.Нийт дүнг тооцож гаргах;

5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах. Иргэний хувьд хууль тогтоомжид тусгагдсан үүргийг гүйцэтгэхэд холбогдон гарах мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа буюу ачааллыг тооцох онцлогтой юм.

## 2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох

Хуулиар хүлээлгэсэн үүргийг болон үүргийн агуулгыг тодорхойлох гэсэн хоёр алхмаар иргэний гүйцэтгэх үүргийг тогтооно. Иргэний гүйцэтгэх үүргийг нэг бүрчлэн, үүргийн агуулга нэг бүрийг тодорхойлно. Энэхүү гүйцэтгэх үүрэгт тухайн хуулиар үүрэг хүлээж буй иргэнээс хуульд заасан мэдээллийг төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд бэлтгэж өгөх, бэлэн байлгах, эсвэл мэдээлэл хүргүүлэхийг ойлгоно.

12

| Д/д                                                    | Хуулийн төслийн зохицуулалт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Үүргийг хэрэгжүүлэх этгээд                | Гүйцэтгэх үүрэг                                       |
|--------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------|-------------------------------------------------------|
| <b>Хоёрдугаар бүлэг.Хяналт шалгалтын үйл ажиллагаа</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                           |                                                       |
| 1.                                                     | 16.1.Улсын байцаагч бодит нөхцөл, байдлыг тогтооход хамааралтай, ач холбогдол бүхий баримт бичиг, мэдээллийг шалгуулагч этгээд болон холбогдох бусад этгээдээс үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах эрхтэй.<br>38.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хяналт шалгалттай холбоотой дараах үүргийг хүлээнэ:<br>38.1.4.улсын байцаагчаас шаардсаны дагуу хяналт шалгалтад шаардлагатай баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх; | Шалгуулагч этгээд, холбогдох бусад этгээд | Улсын байцаагчид баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх |

Улсын байцаагчид баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх нь шалгуулагч этгээд, холбогдох бусад этгээдэд хамаарах үүрэг бөгөөд шалгуулагч этгээдэд хүлээлгэсэн үүргийг хуулийн этгээдэд үүсэх үүрэг хэсэгт авч үзсэн.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр иргэнд хүлээлгэсэн дээрх үүргийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн хяналт шалгалтын тухай хуультай харьцуулан үзье.

| Д/д                                                    | Хуулиар хүлээлгэсэн үүрэг                             | ТХШтХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл | Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа ТХШтХ    | Тайлбар                                            |
|--------------------------------------------------------|-------------------------------------------------------|---------------------------------------|---------------------------------------------|----------------------------------------------------|
| <b>Хоёрдугаар бүлэг.Хяналт шалгалтын үйл ажиллагаа</b> |                                                       |                                       |                                             |                                                    |
| 1.                                                     | Улсын байцаагчид баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх | 16.1, 38.1, 38.1.4                    | 10.9.4 <sup>13</sup> , 10.9.8 <sup>14</sup> | Өөрчлөлт ороогүй. Иргэний үүрэг болгон тодруулсан. |

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр иргэнээс баримт бичиг, мэдээллийг гаргуулан авах улсын байцаагчийн эрхийг тодруулан хуульчилсан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн хяналт шалгалтын тухай хуульд улсын байцаагч нь холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас

<sup>13</sup> ТХШтХ-ийн 10.9.4-т “Мэргэжлийн хяналтын улсын байцаагч хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах эрхтэй” хэмээн заасан.

<sup>14</sup> ТХШтХ-ийн 10.9.8-д “Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах эрхтэй” хэмээн заасан.

баримт бичиг, мэдээллийг гаргуулан авахаар тусгагдсан бөгөөд “иргэнээс” гэсэн зохицуулалт байхгүй болно.

## 2.2.Иргэнд үүсэх зардал, ачааллыг тооцох

Иргэнд үүсэх зардал, ачааллыг үүргийг гүйцэтгэхэд хийгдэх ажиллагаа, зарцуулах хугацаа, зарцуулах мөнгийг тодорхойлох гэсэн гурван алхмаар тооцно. Тухайн үүргийг гүйцэтгэхэд иргэнээс зайлшгүй хийгдэх үйл ажиллагааг нэг бүрчлэн тодорхойлно. Үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацаа, үүргийг хэрэгжүүлэхэд гарах мөнгөн зардлыг мөн тооцно.

13

| Д/д | Гүйцэтгэх үүрэг                                       | Агуулга                                       |
|-----|-------------------------------------------------------|-----------------------------------------------|
| 1.  | Улсын байцаагчид баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх | 1.Баримт бичиг, мэдээлэлтэй танилцах          |
|     |                                                       | 2.Мэдээлэл цуглуулах                          |
|     |                                                       | 3.Баримт бичиг, мэдээллийг боловсруулах       |
|     |                                                       | 4.Мэдээлэл, баримт бичгийг нягтлах            |
|     |                                                       | 5.Баримт бичиг, мэдээллийг хувилах, олшруулах |
|     |                                                       | 6.Баримт бичиг, мэдээллийг цахимаар илгээх    |

Мэргэжлийн хяналтын байгууллагаар үйлчлүүлж байсан хуулийн этгээдээс авсан судалгааны үр дүнд үндэслэн иргэний гүйцэтгэх үйл ажиллагааны хугацааг тодорхойлов.

| Д/д | Гүйцэтгэх үүрэг                                       | Агуулга                                       | Зарцуулах хугацаа (минут) |
|-----|-------------------------------------------------------|-----------------------------------------------|---------------------------|
| 1.  | Улсын байцаагчид баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх | 1.Баримт бичиг, мэдээлэлтэй танилцах          | 20                        |
|     |                                                       | 2.Баримт бичиг, мэдээлэл цуглуулах            | 120                       |
|     |                                                       | 3.Баримт бичиг, мэдээллийг боловсруулах       | 180                       |
|     |                                                       | 4.Мэдээлэл, баримт бичгийг нягтлах            | 60                        |
|     |                                                       | 5.Баримт бичиг, мэдээллийг хувилах, олшруулах | 20                        |
|     |                                                       | 6.Баримт бичиг, мэдээллийг цахимаар илгээх    | 10                        |
|     |                                                       | <b>Нэг иргэний зарцуулах хугацаа</b>          | <b>410</b>                |

Улсын байцаагчийн шаардсан баримт бичиг, мэдээллийг иргэн гаргаж өгөхөд зарцуулах хугацаа нь баримт бичгийн нэр төрөл, тоо хэмжээнээс хамааран харилцан адилгүй байх хэдий ч дунджаар 410 минут зарцуулахаар байна.

Зардлыг тооцоход тухайн үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс зайлшгүй гарах мөнгөөр хэмжигдэх бодит, тогтсон зардлыг тооцно.

| Д/д | Гүйцэтгэх үүрэг                                       | Үүргийн агуулга                               | Мөнгөн зардал (төгрөг) |
|-----|-------------------------------------------------------|-----------------------------------------------|------------------------|
| 1.  | Улсын байцаагчид баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх | 1.Баримт бичиг, мэдээлэлтэй танилцах          | -                      |
|     |                                                       | 2.Баримт бичиг, мэдээлэл цуглуулах            | -                      |
|     |                                                       | 3.Баримт бичиг, мэдээллийг боловсруулах       | -                      |
|     |                                                       | 4.Мэдээлэл, баримт бичгийг нягтлах            | -                      |
|     |                                                       | 5.Баримт бичиг, мэдээллийг хувилах, олшруулах | 1000                   |
|     |                                                       | 6.Баримт бичиг, мэдээллийг цахимаар илгээх    | -                      |
|     |                                                       | <b>Нэг иргэнд үүсэх мөнгөн зардал</b>         | <b>1000</b>            |

Баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, мэдээлэл цуглуулах, боловсруулах, нягтлах, илгээхэд иргэнээс мөнгөн зардал гарахгүй бөгөөд иргэн эдгээр ажиллагааг гүйцэтгэхэд тодорхой хугацаа зарцуулах нь ойлгомжтой юм. Баримт бичиг, мэдээллийг хувилах,

олшруулахад иргэнээс мөнгөн зардал гарах бөгөөд энэ зардал нь олшруулах баримт бичиг, мэдээллийн тоо хэмжээнээс хамаарна. Нэг иргэн дунджаар 20 хуудас материал, нэг хуудсыг нь 50 төгрөгөөр хувилуулна гэж тооцвол 1000 төгрөгийн зардал гарна.

### 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох

Энэ үе шатанд иргэний гүйцэтгэх үүргийг тухайн харилцаанд оролцогч хэдэн иргэн жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг хуанлийн нэг жилээр тооцож гаргана. Тоон үзүүлэлтийг тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлэн тооцно. Тохиолдлын тоо нь тухайн үүргийг гүйцэтгэх иргэний тоо; давтамжийн тоо нь уг үүргийг нэг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг илэрхийлсэн үзүүлэлт болно.

14

Мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт шалгалт хийхдээ жилд хэчнээн иргэнээс баримт бичиг, мэдээлэл шаардан авдаг, энэ нь жилд хэдэн удаа хийгддэг талаарх мэдээлэл олдсонгүй. Иймд аргачлалд заасны дагуу ажиглалт, таамаглалын аргыг ашиглан тохиолдлын болон давтамжийн тоог тодорхойллоо. Мэргэжлийн хяналтын байгууллагын сүүлийн гурван жилийн хяналт шалгалтын төлөвлөгөөний гүйцэтгэлээс үзэхэд жилд дунджаар 20000 объектод хяналт шалгалт хийж байна. Эндээс улсын байцаагч 20000 шалгуулагч хуулийн этгээдээс шаардлагатай баримт бичиг, мэдээллийг авдаг гэсэн дүгнэлт хийж болно. Гэсэн хэдий ч улсын байцаагч холбогдох бусад этгээдээс зарим баримт бичиг, мэдээллийг гаргуулах эрхтэй.

Улсын байцаагч шалгуулагч хуулийн этгээдэд өөрт нь байхгүй, эсхүл бусад этгээдийн мэдлийн баримт бичиг, мэдээллийг холбогдох бусад этгээдээс гаргуулах шаардлагатай. Холбогдох бусад этгээд нь төрийн, нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хуулийн этгээд, иргэн байх боломжтой. Холбогдох бусад этгээдээс баримт бичиг, мэдээлэл гаргуулах шаардлага нийт шалгалтын дийлэнх хувьд нь үүсэхгүй байх магадлалтай. Өөрөөр хэлбэл; нийт шалгалтын дийлэнх буюу 66.6 хувьд нь шалгуулагч этгээд баримт бичиг, мэдээллээ өөрөө гаргаж өгөх боломжтой. Холбогдох бусад этгээд нь төрийн байгууллага, нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, төрийн бус байгууллага, иргэн гэсэн таван субъект байх боломжтой хэмээн тооцвол иргэнд хамаарах нь нийт магадлалын тавны нэг буюу 20 хувь юм. 20000 шалгуулагч хуулийн этгээдийн 33.4 хувь нь 6680, үүний хорин хувь нь 1336 болно. Тодруулбал, уг үүргийг гүйцэтгэх иргэн буюу тохиолдлын тоо нь 1336 байна. Баримт бичиг, мэдээллийг улсын байцаагчид гаргаж өгөх үүрэг нь тухайн жилд нэг удаа хийгдэх тул давтамжийн тоо нь нэг болно.



$$20000 * 33.4 \text{ хувь} = 6680; 6680 * 20 \text{ хувь} = 1336 \text{ иргэн}$$

Хуулиар хүлээлгэсэн үүргийг гүйцэтгэх иргэн буюу тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлэн тоон үзүүлэлтийг гаргана.

| Д/д | Гүйцэтгэх үүрэг                                       | Үүргийн агуулга                               | Тохиолдлын тоо | Давтамж | Тоон үзүүлэлт |
|-----|-------------------------------------------------------|-----------------------------------------------|----------------|---------|---------------|
| 1.  | Улсын байцаагчид баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх | 1.Баримт бичиг, мэдээлэлтэй танилцах          | 1336           | 1       | 1336          |
|     |                                                       | 2.Баримт бичиг, мэдээлэл цуглуулах            | 1336           | 1       | 1336          |
|     |                                                       | 3.Баримт бичиг, мэдээллийг боловсруулах       | 1336           | 1       | 1336          |
|     |                                                       | 4.Мэдээлэл, баримт бичгийг нягтлах            | 1336           | 1       | 1336          |
|     |                                                       | 5.Баримт бичиг, мэдээллийг хувилах, олшруулах | 1336           | 1       | 1336          |
|     |                                                       | 6.Баримт бичиг, мэдээллийг цахимаар илгээх    | 1336           | 1       | 1336          |

#### 2.4.Нийт зардал, ачааллын дүнг тооцох

Энэ үе шатанд иргэнд үүсэх зардал болон ачааллыг тооцно. Нэг иргэнээс баримт бичгийг хувилах, олшруулахад 1000 төгрөгийн нэмэлт зардал гарах бөгөөд 1336 иргэнээс нийт 1,336,000 төгрөгийн зардал гарна.

$1336 \text{ иргэн} * 1000 \text{ төгрөг} = 1,336,000 \text{ төгрөг}$

Хуулиар хүлээлгэсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэнд үүсэх ачааллыг тооцёё. Иргэнд үүсэх ачаалал нь хугацааны зарцуулалтыг тоон үзүүлэлтээр үржүүлснээр тодорхойлогдоно.

| Д/д | Гүйцэтгэх үүрэг                                       | Агуулга                                       | Зарцуулах хугацаа (минут) | Тоон үзүүлэлт | Ачаалал (минут) |
|-----|-------------------------------------------------------|-----------------------------------------------|---------------------------|---------------|-----------------|
| 1.  | Улсын байцаагчид баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх | 1.Баримт бичиг, мэдээлэлтэй танилцах          | 20                        | 1336          | 26720           |
|     |                                                       | 2.Баримт бичиг, мэдээлэл цуглуулах            | 120                       | 1336          | 160320          |
|     |                                                       | 3.Баримт бичиг, мэдээллийг боловсруулах       | 180                       | 1336          | 240480          |
|     |                                                       | 4.Мэдээлэл, баримт бичгийг нягтлах            | 60                        | 1336          | 80160           |
|     |                                                       | 5.Баримт бичиг, мэдээллийг хувилах, олшруулах | 20                        | 1336          | 26720           |
|     |                                                       | 6.Баримт бичиг, мэдээллийг цахимаар илгээх    | 10                        | 1336          | 13360           |
|     |                                                       | <b>Нийт ачаалал</b>                           | <b>410</b>                |               | <b>547,760</b>  |

Улсын байцаагчид баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөхөд 1336 иргэнд нийт 547,760 минут буюу 9129 цагийн ачаалал үүсэх урьдчилсан тооцоо гарч байна.

#### 2.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

Энэ үе шатанд үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, иргэнд үүсгэх зардал, ачааллыг бууруулах боломж байгаа эсэхийг шалгана. Иргэний гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардал, ачааллыг бууруулах боломж байгаа эсэхийг дараах асуултаар нягтална:

- шинээр үүсгэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;
- мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх;
- мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;
- мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;
- хамрагдах иргэдийн тоог багасгах боломж байгаа эсэх;
- мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх.

Улсын байцаагчийн шаардсан баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх иргэний үүрэг нь шинээр үүсч байгаа үүрэг биш; түүнчлэн баримт бичиг, мэдээллийн агуулга хуульд тодорхой тусгагдаагүй тул зарим агуулгаас татгалзах, бууруулах боломжгүй юм. Баримт бичиг, мэдээлэл хүргүүлэх давтамжийг боломжит хамгийн бага түвшинд буюу нэгээр авсан тул давтамжийг бууруулах үндэслэлгүй болно.

Харин иргэдийн тоог бууруулах боломжийн хувьд дараах боломж байна. Улсын байцаагчид баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөхөд 1336 иргэнд нийт 547,760 минутын ачаалал; 1.3 сая төгрөгийн нэмэлт зардал шаардлагатай. Иргэнд үүсэх ачаалал, зардлыг бууруулахын тулд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалт тодорхой байх ёстой. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 16.1-д “Улсын байцаагч бодит нөхцөл, байдлыг тогтооход хамааралтай, ач холбогдол бүхий баримт бичиг, мэдээллийг шалгуулагч этгээд болон холбогдох бусад этгээдээс үнэ төлбөргүйгээр гаргуулан авах, танилцах эрхтэй”; 33.1.3-т “улсын байцаагч нь цахим болон цаасан суурьтай баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, үнэ төлбөргүйгээр гаргуулан авах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”; 38.1.4-т “иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь улсын байцаагчаас шаардсаны дагуу хяналт шалгалтад шаардлагатай баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй” хэмээн тусгасан. Эдгээр зохицуулалтад холбогдох бусад этгээд буюу иргэнээс баримт бичиг гаргуулах нөхцөлийг тодорхой болгох, баримт бичгийн нэр төрлийг заах зэрэг өөрчлөлт оруулан сайжруулахыг зөвлөж байна.

Улсын байцаагч иргэнээс баримт бичиг, мэдээлэл гаргуулахаар шаардах нөхцөл, иргэний гаргаж өгөх баримт бичиг, мэдээллийн нэр төрөл тодорхой нөхцөлд иргэнд үүсэх нэмэлт ачаалал, зардлын хэмжээ буурах боломжтой. Иргэдээс баримт бичиг, мэдээллийг цахимаар хүргүүлэхээр тооцсон.

*Нэг иргэнд үүсэх нэмэлт зардал, ачааллын урьдчилсан тооцоо:*  
**1000 (нэг мянга) төгрөгийн зардал,**  
**410 (дөрвөн зуун арав) минутын ачаалал.**

### **Гурав.Төрийн байгууллагын зардлын тооцоо**

Төрийн байгууллагын зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу дараах таван үе шатаар тооцно:

- 1.Үүргийг тогтоох;
- 2.Хүний нөөцийг тодорхойлох;
- 3.Гарах зардлыг тооцох;
- 4.Нийт зардлын дүнг тооцох;
- 5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

#### **3.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тогтоох**

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг зарцуулах хугацаа болон тохиолдлын тоог тодорхойлох гэсэн хоёр дарааллаар тогтооно. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалтаар үүрэг хүлээсэн байгууллага нэг бүрийг; түүний гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн тодорхойлно. Гүйцэтгэх үүрэгт хуулиар олгогдсон бүртгэл хийх, зөвшөөрөл олгох зэрэг төрийн байгууллагаас үзүүлж байгаа ажил, үйлчилгээг ойлгоно.



| Д/д                                                                                                    | Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Хэрэгжүүлэх байгууллага | Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ                                                                                                                                          |
|--------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хоёрдугаар бүлэг.Хяналт шалгалтын үйл ажиллагаа,<br/>Хоёрдугаар дэд бүлэг.Хяналт шалгалтын арга</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                         |                                                                                                                                                                                                  |
| 1.                                                                                                     | 16.2.Улсын байцаагчийн шаардлагатай тохиолдолд баримт бичиг, мэдээллийг акт үйлдэн хүлээн авч, шалгалтын дүн гарсны дараа тухайн этгээдэд буцааж өгнө.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Улсын байцаагч          | -Баримт бичиг, мэдээллийг акт үйлдэн хүлээн авах;<br>-Шалгалтын дүн гарсны дараа тухайн этгээдэд буцааж өгөх;                                                                                    |
| 2.                                                                                                     | 17.1.Улсын байцаагч бодит нөхцөл, байдлыг тогтоох зорилгоор шалгуулагч этгээд болон бусад холбогдох этгээдээс тайлбар авах эрхтэй.<br>17.2.Тайлбарыг биечлэн эсхүл бичгээр авч болно. Тайлбарыг биечлэн авах тохиолдолд тодорхой асуулт тавьж, хариулт авах хэлбэрээр гүйцэтгэнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | Улсын байцаагч          | -Тайлбар авах;<br>-Биечлэн тайлбар авахад асуулт бэлтгэсэн байх                                                                                                                                  |
| 3.                                                                                                     | 18.1.Улсын байцаагч ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүн, барилга, байгууламж, техник, тоног төхөөрөмж зохих шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор шалгуулагч этгээдийн үйл ажиллагаа явуулдаг нутаг дэвсгэр, газар, барилга байгууламж, албан газар, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа, бараа, эд зүйлд үзлэг хийх эрхтэй.<br>18.2.Үзлэгийг шалгуулагч этгээд, түүний төлөөллийг байлцуулан хийнэ.<br>Шалгуулагч этгээд, түүний төлөөлөл ирээгүй тохиолдолд улсын байцаагч үзлэг хийх ажиллагаанд хөндлөнгийн гэрчийг байлцуулах, эсхүл үзлэгийн ажиллагааг гэрэл зураг, дуу, дүрсний бичлэгээр бэхжүүлэх арга хэмжээ авна.<br>19.1.Улсын байцаагч барилга байгууламж, ажлын байр, бодис, бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, тоног төхөөрөмж, даралтад сав, шугам хоолойны чанар аюулгүй байдал нь зохих шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор туршилт, хэмжилт, магадлал хийх эрхтэй.<br>19.3.Туршилт, хэмжилт, магадлал хийхэд энэ хуулийн 18.2-т заасан журам нэгэн адил үйлчилнэ. | Улсын байцаагч          | Үзлэг, туршилт, хэмжилт, магадлалыг дараах байдлаар хийнэ:<br>-шалгуулагч этгээд, төлөөлөгчийг байлцуулах;<br>-хөндлөнгийн гэрчийг байлцуулах;<br>-гэрэл зураг, дуу, дүрсний бичлэгээр бэхжүүлэх |
| 4.                                                                                                     | 20.1.Улсын байцаагч агаар, ус, хөрс, бодис, бараа, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, эд зүйлс нь зохих шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор тэдгээрээс дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулах эрхтэй.<br>20.2.Улсын байцаагч дээж авахдаа дараах ажиллагааг гүйцэтгэнэ:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Улсын байцаагч          | -Агаар, ус, хөрс, бодис, бараа, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, эд зүйлсээс дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулах;                                                            |

|                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                              |                                                                                                                                                          |
|---------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                   | <p>20.2.1.Дээж авсан тухай акт үйлдэх ба актад дараах зүйлийг тусгана:</p> <p>20.2.1.а. акт үйлдсэн газар, он, сар, өдөр, цаг, минут;</p> <p>20.2.1.б.шалгуулагч этгээдийн нэр, хаяг;</p> <p>20.2.1.в.дээж авахад байлцсан шалгуулагч этгээд, эсхүл түүнийг төлөөлсөн этгээдийн нэр, албан тушаал;</p> <p>20.2.1.г.дээж авсан улсын байцаагчийн нэр, албан тушаал;</p> <p>20.2.1.д.дээж авах үндэслэл, шаардлага;</p> <p>20.2.1.е.бараа, бүтээгдэхүүнээс дээж авах тохиолдолд импортлосон улс болон үйлдвэрлэгчийн нэр;</p> <p>20.2.1.ё.дээж авсан хугацаа, бараа, бүтээгдэхүүний нэр, төрөл, савлалт, цувралын дугаар, үйлдвэрлэсэн болон хадгалалтын дуусах хугацаа, нийт импортлосон болон дээжийн хэмжээ;</p> <p>20.2.2.Энэ хуулийн 20.2.1-д заасан актыг гурван хувь үйлдэх бөгөөд шалгуулагч этгээд болон итгэмжлэгдсэн лабораторид тус тус нэг хувийг өгч, үлдэх хувийг шалгалтын хувийн хэрэгт хавсаргана.</p> <p>20.2.3.дээжинд хийсэн шинжилгээний үр дүнг шалгуулагч этгээдэд нэн даруй мэдэгдэх;</p> <p>20.2.4.шалгуулагч этгээдийн хүсэлтээр хоёр дахь дээжийг авч шинжилгээнд хамруулж болно.</p> <p>20.4.Улсын байцаагч дээжийн бүрэн бүтэн байдал, ариун чанар, хадгалалт болон тээвэрлэлтийн горимыг хангах үүрэгтэй.</p> <p>20.5.Дээж авснаар шалгуулагч этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагаа алдагдах тохиолдолд дээжийг шинжилгээнд хамруулсны дараа шалгуулагч этгээдэд буцаан өгнө.</p> |                              | <p>-Дээж авсан тухай актыг гурван хувь үйлдэх</p> <p>-Дээжинд хийсэн шинжилгээний үр дүнг шалгуулагч этгээдэд нэн даруй мэдэгдэх</p>                     |
| <p><b>Хоёрдугаар бүлэг.Хяналт шалгалтын үйл ажиллагаа, Гуравдугаар дэд бүлэг.Шалгалт хийх</b></p> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                              |                                                                                                                                                          |
| 5.                                                                                                | <p>21.1.Зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсээр нэвтрүүлэх үеийн шалгалт болон хуульд өөрөөр зааснаас бусад шалгалтыг эрх бүхий этгээдийн баталсан удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.</p> <p>21.2.Шалгалтын удирдамжид дараах зүйлийг тусгана:</p> <p>21.2.1.он, сар, өдөр, удирдамжийн нэгдсэн дугаар;</p> <p>21.2.2.шалгалтын зорилго, үндэслэл;</p> <p>21.2.3.шалгалтын хамрах хүрээ;</p> <p>21.2.4.шалгуулагч этгээд, объектын нэр;</p> <p>21.2.5.шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч;</p> <p>21.2.6.шалгалт хийх хугацаа.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Хяналт шалгалтын байгууллага | <p>-Эрх бүхий этгээдээр удирдамж батлуулах, удирдамжийн дагуу шалгалтыг хэрэгжүүлэх;</p> <p>-Шалгалтын удирдамжид дараах зүйлийг тусган боловсруулах</p> |

|     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                |                                                                                 |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|---------------------------------------------------------------------------------|
| 6.  | <p>22.1.Улсын байцаагч шалгалтын явцад тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:</p> <p>22.1.1.шалгалтын явц болон шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал;</p> <p>22.1.2.улсын байцаагчийн санал, дүгнэлт, авсан арга хэмжээ;</p> <p>22.1.3.шалгуулагч этгээдийн санал, хүсэлт.</p> <p>22.2.Улсын байцаагч шалгалтын тэмдэглэлийн хувийг шалгуулагч этгээдэд өгнө. Шалгуулагч этгээд тэмдэглэлтэй танилцсан тухай гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв гарын үсэг зурахаас татгалзсан бол улсын байцаагч энэ тухай тэмдэглэлд тусгана.</p> <p>22.3.Шалгалтын явцад хийсэн дуу, дүрсний, бичлэг, гэрэл зургийг шалгалтын тэмдэглэлд хавсаргана.</p> | Улсын байцаагч | Шалгалтын явцад тэмдэглэл хөтлөх                                                |
| 7.  | <p>23.1.Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 өдөр хүртэл байх бөгөөд үүнд шалгалтын дүн гаргах хугацаа хамаарахгүй.</p> <p>23.2.Нөхцөл байдлыг тодруулан шалгах шаардлагатай гэж үзвэл удирдамжийг баталсан албан тушаалтан шалгалт хийх хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | Улсын байцаагч | Шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 өдөр хүртэл байна                          |
| 8.  | <p>24.1.Улсын байцаагч шалгалт дуусснаас хойш ажлын 5 өдрийн дотор шалгалтын танилцуулга бичиж, дээд шатны улсын байцаагч болон удирдах албан тушаалтанд танилцуулна.</p> <p>24.3.Шалгалтын танилцуулга нь шалгалтын талаарх ерөнхий мэдээлэл, түүний үр дүн, тогтоогдсон нөхцөл байдал, авсан болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлтийг агуулсан байна.</p>                                                                                                                                                                                                                                                                                            | Улсын байцаагч | Шалгалт дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор шалгалтын танилцуулга боловсруулах |
| 9.  | 24.4.Шалгуулагч этгээдэд шалгалтын дүнг танилцуулна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Улсын байцаагч | Шалгуулагч этгээдэд шалгалтын дүнг танилцуулах                                  |
| 10. | <p>25.1.Улсын байцаагч хяналт шинжилгээ болон өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн улсын байцаагчийн албан шаардлагын биелэлтэд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор гүйцэтгэлийн шалгалт явуулж болно.</p> <p>25.2.Гүйцэтгэлийн шалгалтыг гагцхүү өмнөх шалгалтаар өгсөн улсын байцаагчийн албан шаардлагад дурдсан асуудлын хүрээнд хийнэ.</p> <p>25.3.Улсын байцаагчаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хэрхэн хангасан талаар шалгуулагч этгээдээс ирүүлсэн хариуг үндэслэн гүйцэтгэлийн шалгалт</p>                                                                                                                                               | Улсын байцаагч | Жинхэнэ биелэлтийг тогтоох зорилгоор гүйцэтгэлийн шалгалт явуулж болох          |

|                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                        |                                                                                                                                                                                                     |
|------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                  | хийх эсэхийг ажлын таван өдрийн дотор шийдвэрлэнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                        |                                                                                                                                                                                                     |
| 11.                                                                                                              | 25.4.Улсын байцаагч дараах тохиолдолд гүйцэтгэлийн шалгалтыг заавал хэрэгжүүлнэ:<br>25.4.1.үйл ажиллагаа, ашиглалтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоосон;<br>25.4.2.бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг хураан авсан, битүүмжилсэн;                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Улсын байцаагч         | Гүйцэтгэлийн шалгалтыг заавал хэрэгжүүлэх                                                                                                                                                           |
| <b>Хоёрдугаар бүлэг.Хяналт шалгалтын үйл ажиллагаа, Дөрөвдүгээр дэд бүлэг.Шалгалтын хүрээнд авах арга хэмжээ</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                        |                                                                                                                                                                                                     |
| 12.                                                                                                              | 26.1.Улсын байцаагч зохих шаардлагад нийцэхгүй байж болзошгүй бараа, бүтээгдэхүүнд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, дээж авч шинжилгээнд хамруулах, холбогдох байгууллагаас мэдээлэл, лавлагаа авах, баримт бичгийн бүрдлийг хангуулах зорилгоор бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийг түр саатуулж болно.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Мэргэжлийн байгууллага | Дүгнэлт гаргах                                                                                                                                                                                      |
| 13.                                                                                                              | 29.1.Улсын байцаагч дараах тохиолдолд бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг хураан авах арга хэмжээг хэрэгжүүлнэ:<br>29.1.1.шалгалтаар хууль, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар худалдан борлуулах, эзэмших, ашиглахыг хориглосон бараа, бүтээгдэхүүн, эд зүйл илэрсэн;<br>29.1.2.шалгуулагч этгээд энэ хуулийн 27.1, 28.1-д заасны дагуу гаргасан улсын байцаагчийн шийдвэрийг тогтоосон хугацаанд сайн дураар биелүүлээгүй;<br>29.1.3.тухайн бараа, бүтээгдэхүүн, эд зүйл нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюултай болох нь тогтоогдсон;<br>29.1.4.хуульд заасан бусад.<br>29.3.Энэ хуулийн 30.1-д заасан улсын байцаагчийн шийдвэрийг шалгуулагч этгээд биелүүлээгүй бол тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг битүүмжилж, лацдах арга хэмжээг авна. | Улсын байцаагч         | Бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг хураан авах арга хэмжээ авах                                                                                                                                        |
| 14.                                                                                                              | 29.4.Энэ хуулийн 29.2, 29.3-т заасны дагуу бараа, бүтээгдэхүүн, эд зүйл, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг битүүмжлэхдээ тэдгээрийг бусдад шилжүүлэх, ашиглуулах, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, шалгуулагч этгээдэд өөрт нь, эсхүл бусад хамаарал бүхий этгээдэд чанар аюулгүй байдлыг алдагдуулахгүйгээр хадгалж, хамгаалах үүрэг хүлээлгэнэ.<br>29.5.Улсын байцаагч энэ хуулийн 29.4-т заасны дагуу тухайн эд зүйл, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хадгалах, хамгаалах үүрэг хүлээсэн хүнд шийдвэрийн хувийг өгч, үүргээ зөрчвөл                                                                                                                                                                                                   | Улсын байцаагч         | -Хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэх шийдвэрийн хувийг өгөх;<br>-Үүргээ зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай сануулах;<br>-Хураан авах, битүүмжлэх арга хэмжээ авахдаа тэмдэглэл үйлдэх |

|     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                      |                                                                                                          |
|-----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|
|     | хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай сануулна.<br>29.6.Улсын байцаагч хураан авах, битүүмжлэх арга хэмжээг авахдаа тэмдэглэл үйлдэж, нэг хувийг шалгуулагч этгээдэд өгнө.                                                                                                                                                                  |                      |                                                                                                          |
| 15. | 30.2.Улсын байцаагч ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг түр зогсоосон тохиолдолд шалгуулагч этгээдэд актын хувийг гардуулна.                                                                                                                                                                                                           | Улсын байцаагч       | Ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг түр зогсоосон тохиолдолд шалгуулагч этгээдэд актыг гардуулах |
| 16. | 30.5.Шалгуулагч этгээд зөрчлөө арилгасан тухай хяналт шалгалтын байгууллагад мэдэгдсэн тохиолдолд улсын байцаагч нэн даруй гүйцэтгэлийн шалгалт хийж үйл ажиллагаа, ашиглалтыг сэргээх эсэхийг шийдвэрлэнэ.                                                                                                                                    | Улсын байцаагч       | Гүйцэтгэлийн шалгалт хийж үйл ажиллагаа, ашиглалтыг сэргээх эсэхийг шийдвэрлэх                           |
| 17. | 31.1.Шалгуулагч этгээд хууль бусаар орлого олсон, бусдад хохирол учруулсан нь тогтоогдсон тохиолдолд улсын байцаагч төлбөрийн акт тогтоож, хохирлыг арилгуулах арга хэмжээг авна.                                                                                                                                                              | Улсын байцаагч       | Төлбөрийн акт тогтоох                                                                                    |
| 18. | 33.2.1.холбогдох байгууллагатай тохиролцон зохих мэргэжлийн хүнийг хяналт шалгалтын үйл ажиллагаанд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;                                                                                                    | Улсын ахлах байцаагч | Лабораторийн буюу магадлан шинжилгээг гүйцэтгэх                                                          |
| 19. | 33.2.2.улсын байцаагчийн шийдвэрээр тогтоосон хугацаанд зөрчил дутагдлаа арилгаагүй иргэн, хуулийн этгээдийн тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох, холбогдох тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах тухай санал, дүгнэлтээ эрх бүхий этгээдэд тавьж шийдвэрлүүлэх;                                                      | Улсын ахлах байцаагч | Санал, дүгнэлтээ эрх бүхий этгээдэд тавьж шийдвэрлүүлэх                                                  |
| 20. | 33.2.3.хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдал нь гэмт хэргийн шинжтэй байвал холбогдох нотлох баримтыг эрх бүхий байгууллагад шилжүүлэн шалгуулах;                                                                                                                                                                                     | Улсын ахлах байцаагч | Холбогдох нотлох баримтыг эрх бүхий байгууллагад шилжүүлэн шалгуулах                                     |
| 21. | 33.2.4.хяналт шалгалтын удирдамжийг батлах;                                                                                                                                                                                                                                                                                                    | Улсын ахлах байцаагч | хяналт шалгалтын удирдамжийг батлах                                                                      |
| 22. | 33.2.5.улсын байцаагчийн шийдвэр, үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;                                                                                                                                                                                                                                             | Улсын ахлах байцаагч | Гомдлыг хянан шийдвэрлэх                                                                                 |
| 23. | 33.2.6.ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, битүүмжлэх, бараа, тээврийн хэрэгслийг түр саатуулах, барааг татан авах, буцаах, эд зүйлийг битүүмжлэх, хураан авах, устгах, нөхөн төлбөр тогтоох талаар гаргасан улсын байцаагчийн шийдвэрт шалгуулагч этгээд гомдол гаргасан эсэхээс нь үл хамааран | Улсын ахлах байцаагч | Улсын байцаагчийн шийдвэрийг хянан үзэх                                                                  |

|                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                     |                                       |                                                                                                                                                                                         |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                            | шийдвэрийг гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянан үзэх;                                                                                                                                                                                                                                         |                                       |                                                                                                                                                                                         |
| 24.                                                                                                                                        | 33.2.7.улсын байцаагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд хяналт тавих.                                                                                                                                                                                                                              | Улсын ахлах байцаагч                  | Улсын байцаагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд хяналт тавих                                                                                                                          |
| 25.                                                                                                                                        | 33.7.Хуулиар тусгайлан эрх олгогдсон улсын байцаагчийн эрхтэй бусад этгээд нь энэ хуулийн 33.6-д заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ:<br>33.7.1.улсын ерөнхий байцаагчтай байгуулсан гэрээнд заасан хамрах хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;                                            | Улсын байцаагчийн эрхтэй бусад этгээд | Улсын ерөнхий байцаагчтай гэрээ байгуулах                                                                                                                                               |
| 26.                                                                                                                                        | 33.7.2.хяналт шалгалтыг давхардуулахгүй байлгах шаардлагыг хангах зорилгоор тухайн жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг мэргэжлийн хяналтын төв байгууллагатай урьдчилан зөвшилцөж, тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдөр батлуулах;                                                          | Улсын байцаагчийн эрхтэй бусад этгээд | Мэргэжлийн хяналтын төв байгууллагатай урьдчилан зөвшилцөж, оны эхний 01 дүгээр сард батлуулах                                                                                          |
| 27.                                                                                                                                        | 33.7.3.шалгалт хийсэн тухай бүрт шалгалтын дүн, тайлангаа тухай бүр мэргэжлийн хяналтын төв байгууллагад хүргүүлэх                                                                                                                                                                                  | Улсын байцаагчийн эрхтэй бусад этгээд | Шалгалтын дүн, тайлангаа тухай бүр мэргэжлийн хяналтын төв байгууллагад хүргүүлэх                                                                                                       |
| 28.                                                                                                                                        | 34.1.Улсын байцаагч хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ импортын мэдэгдэл, экспорт, импортын гэрчилгээ, зөвлөмж, мэдэгдэл, дүгнэлт, албан шаардлага, акт болон мэргэжлийн хяналтын байгууллагын үйлдэх бусад баримт бичиг үйлдэж баталгаажуулна.                  | Улсын байцаагч                        | Импортын мэдэгдэл, экспорт, импортын гэрчилгээ, зөвлөмж, мэдэгдэл, дүгнэлт, албан шаардлага, акт болон мэргэжлийн хяналтын байгууллагын үйлдэх бусад баримт бичиг үйлдэж баталгаажуулах |
| 29.                                                                                                                                        | 36.2.Улсын байцаагчийн тогтоосон төлбөрийн актыг шалгуулагч этгээд сайн дураар биелүүлээгүй бол улсын байцаагчийн шийдвэрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 284 дүгээр зүйлд заасны дагуу шүүхээр баталгаажуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар албадан гүйцэтгүүлнэ. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага | Улсын байцаагчаас тогтоосон төлбөрийн актыг албадан гүйцэтгэх                                                                                                                           |
| <b>Тавдугаар бүлэг.Мэргэжлийн хяналтын байгууллага, Нэгдүгээр дэд бүлэг.Мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцоо, бүтэц, бүрэлдэхүүн</b> |                                                                                                                                                                                                                                                                                                     |                                       |                                                                                                                                                                                         |
| 30.                                                                                                                                        | 43.1.2.тандалт судалгаа, хяналт шинжилгээ хийх, салбарын нийтлэг асуудлаар сургалт зохион байгуулах, хяналтын хуудсын хүрээнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх;                                                                                                                                      | Мэргэжлийн хяналтын байгууллага       | -Тандалт судалгаа, хяналт шинжилгээ хийх,<br>-Сургалт зохион байгуулах,<br>-Хяналтын хуудасны хүрээнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх                                                   |
| 31.                                                                                                                                        | 43.1.3.хуульд заасны дагуу зөвшөөрөл, гэрчилгээ, мэдэгдэл олгох, дүгнэлт гаргах                                                                                                                                                                                                                     | Мэргэжлийн хяналтын байгууллага       | Хуульд заасны дагуу зөвшөөрөл, гэрчилгээ,                                                                                                                                               |

|                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                     |                                                                                                                        |
|--------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                  | замаар хянан баталгаажуулах үйл ажиллагаа явуулах;                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                     | мэдэгдэл олгох, дүгнэлт гаргах                                                                                         |
| 32.                                                                                              | 43.1.4.эрсдэл, аюул, осол үүсгэж болзошгүй объект, үйл ажиллагааг тодорхойлж, тэдгээрийн эрсдэлийг үнэлэх, шалтгаан, нөхцөлийг тогтоох, эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээг авах, үр дүнг нийтэд мэдээлэх;                                                                                                                                                                                                                                                                      | Мэргэжлийн хяналтын байгууллага     | Эрсдэлийг үнэлэх, шалтгаан, нөхцөлийг тогтоох, эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээг авах, үр дүнг нийтэд мэдээлэх |
| 33.                                                                                              | 43.1.6.лабораторийн шинжилгээ хийх;                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | Мэргэжлийн хяналтын байгууллага     | Лабораторийн шинжилгээ хийх                                                                                            |
| 34.                                                                                              | 44.1.3.хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан дүрэм, журам, заавар, аргачлал, стандарт, хяналтын хуудсыг боловсруулж батлах;                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Мэргэжлийн хяналтын төв байгууллага | Хуульд заасан дүрэм, журам, заавар, аргачлал, хяналтын хуудсыг боловсруулж батлах                                      |
| 35.                                                                                              | 44.1.8.хяналт шалгалтын статистикийн мэдээлэл, удирдлагын нэгдсэн санг бүрдүүлэх, удирдах зохион байгуулах;<br>47.1.Мэргэжлийн хяналтын байгууллага хяналт шалгалтын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, зөрчил дутагдлын шалтгаан, нөхцөлийг тогтоох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого боловсруулах, иргэн, хуулийн этгээдэд шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор хяналт шалгалтын статистикийн мэдээлэл, удирдлагын нэгдсэн сан /цаашид “Мэдээллийн сан” гэх/-тай байна. | Мэргэжлийн хяналтын төв байгууллага | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээлэл, удирдлагын нэгдсэн сан бүрдүүлэх                                                   |
| 36.                                                                                              | 46.2.Мэргэжлийн хяналтын төв байгууллага энэ хуулийн 46.3-т заасан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг батална.<br>8.1.Хяналт шалгалтын байгууллага тухайн жилд хэрэгжүүлэх төлөвлөгөөт хяналт шалгалтын төлөвлөгөөг өмнөх оны 12 дугаар сарын 25-ний өдрийн дотор баталж, өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.                                                                                                                                     | Мэргэжлийн хяналтын төв байгууллага | Төлөвлөгөөт шалгалтын ерөнхий төлөвлөгөөг өмнөх оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор батлах, нийтэд мэдээлэх         |
| 37.                                                                                              | 47.3.Улсын байцаагч хяналт шалгалт хийсэн тухай бүрт хяналт шалгалттай холбогдох баримт бичгийг цахим системд бүртгэж, хөтөлнө.                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Улсын байцаагч                      | Тухай бүр хяналт шалгалттай холбогдох баримт бичгийг цахим системд бүртгэх хөтлөх                                      |
| <b>Зургаадугаар бүлэг.Мэргэжлийн хяналтын байгууллагаас төрийн бусад байгууллагатай харилцах</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                     |                                                                                                                        |
| 38.                                                                                              | 54.1.Мэргэжлийн хяналтын төв байгууллага хариуцсан чиглэлийн хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, стандартын хэрэгжилтийн байдал, үр дүнгийн талаарх тайланг тухай бүр Засгийн газарт танилцуулна.                                                                                                                                                                                                                                                                      | Мэргэжлийн хяналтын төв байгууллага | Тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Засгийн газарт танилцуулах                                                    |
| 39.                                                                                              | 55.3.Яам, агентлаг нь мэргэжлийн хяналтын төв байгууллагаас өгсөн санал, зөвлөмж, албан шаардлагын хариуг тогтоосон хугацаанд өгөх үүрэгтэй.                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Яам, агентлаг                       | Санал, зөвлөмжийн хариуг тогтоосон хугацаанд өгөх                                                                      |
| 40.                                                                                              | 56.6.Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн санал, албан                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Нутгийн захиргааны байгууллага      | Санал, зөвлөмжийн хариуг тогтоосон хугацаанд өгөх                                                                      |

|  |                                                                 |  |  |
|--|-----------------------------------------------------------------|--|--|
|  | шаардлага, зөвлөмжийн хариуг тогтоосон хугацаанд өгөх үүрэгтэй. |  |  |
|--|-----------------------------------------------------------------|--|--|

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалтаар төрийн болон нутгийн захиргааны найман байгууллага, таван албан тушаалтанд үүрэг хүлээлгэжээ. Төрийн болон нутгийн захиргааны найман байгууллагыг дурдвал: 1/.хяналт шалгалтын байгууллага; 2/.мэргэжлийн байгууллага; 3/.мэргэжлийн хяналтын байгууллага; 4/.мэргэжлийн хяналтын төв байгууллага; 5/.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага; 6/.ям; 7/.агентлаг; 8/.нутгийн захиргааны байгууллага. Хуулиар үүрэг хүлээлгэсэн таван албан тушаалтныг дурдвал: 1/.улсын байцаагч; 2/.улсын ахлах байцаагч; 3/.улсын ерөнхий байцаагч; 4/.улсын байцаагчийн эрхтэй бусад этгээд; 5/.нутгийн захиргааны албан тушаалтан.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр төрийн байгууллагад хүлээлгэсэн дээр дурдсан 40 үүргийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн хяналт шалгалтын тухай хуультай харьцуулан үзье.

| Д/д                                                     | Хуулиар хүлээлгэсэн үүрэг                                                                                                                                                        | ТХШТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл | Хүчин төгөлдөр үйлчилж байгаа ТХШТХ                                  | Тайлбар                                                         |
|---------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------|----------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|
| <b>Хэрэгжүүлэх субъект.Хяналт шалгалтын байгууллага</b> |                                                                                                                                                                                  |                                       |                                                                      |                                                                 |
| 1.                                                      | -Эрх бүхий этгээдээр удирдамж батлуулах, удирдамжийн дагуу шалгалтыг хэрэгжүүлэх;<br>-Шалгалтын удирдамжид дараах зүйлийг тусган боловсруулах                                    | 21.1, 22.2                            | 5.2 <sup>15</sup>                                                    | Өөрчлөлт ороогүй.                                               |
| <b>Хэрэгжүүлэх субъект.Улсын байцаагч</b>               |                                                                                                                                                                                  |                                       |                                                                      |                                                                 |
| 2.                                                      | -Баримт бичиг, мэдээллийг акт үйлдэн хүлээн авах;<br>-Шалгалтын дүн гарсны дараа тухайн этгээдэд буцааж өгөх;<br>-Баримт бичгийг шалгалтын хувийн хэрэгт хавсаргахаар хуулбарлах | 16.2                                  | Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандарт <sup>16</sup> | Стандартаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгасан. |
| 3.                                                      | -Тайлбар авах;<br>-Биечлэн тайлбар авахад асуулт бэлтгэсэн байх                                                                                                                  | 17.1, 17.2                            | 10.9.4. <sup>17</sup>                                                | Өөрчлөлт ороогүй.                                               |

<sup>15</sup> ТХШТХ-ийн 5.2-т “Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийх бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана: 5.2.1.он, сар, өдөр, удирдамжийн нэгдсэн дугаар; 5.2.2.шалгалтын зорилго, үндэслэл; 5.2.3.шалгалтын төрөл, арга, хэлбэр; 5.2.4.шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, объектын нэр; 5.2.5.шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч; 5.2.6.шалгалт эхлэх болон дуусах хугацаа; 5.2.7.өмнө хийсэн шалгалтын талаархи мэдээлэл.” гэж заасан.

<sup>16</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019.04.23-ны өдрийн А/67 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандартын 12.6-д “Улсын байцаагч нь хяналт шалгалтад шаардлагатай баримт бичгийг шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтнаар гарын үсэг зуруулан хүлээн авч, шалгалт дууссаны дараа албан ёсоор хүлээлгэж өгнө. Шаардлагатай бол нотлох баримт болгохоор хувилуулж авна.” гэж заасан.

<sup>17</sup> ТХШТХ-ийн 10.9.4-т “Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах эрхтэй,” гэж заасан.



|    |                                                                                                                                                                                                                                                                    |                              |                                                                                                          |                                                                 |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------|
| 4. | Үзлэг, туршилт, хэмжилт, магадлалыг дараах байдлаар хийнэ:<br>-шалгуулагч этгээд, төлөөлөгчийг байлцуулах;<br>-хөндлөнгийн гэрчийг байлцуулах;<br>-гэрэл зураг, дуу, дүрсний бичлэгээр бэхжүүлэх                                                                   | 18.1, 18.2, 19.1, 19.3       | З <sup>1</sup> .1.2 <sup>18</sup> , Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандарт <sup>19</sup> | Өөрчлөлт ороогүй.                                               |
| 5. | -Агаар, ус, хөрс, бодис, бараа, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, эд зүйлсээс дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулах;<br>-Дээж авсан тухай актыг гурван хувь үйлдэх<br>-Дээжинд хийсэн шинжилгээний үр дүнг шалгуулагч этгээдэд нэн даруй мэдэгдэх | 20.1, 20.2.1, 20.2.2, 20.3   | 5 <sup>5</sup> .Шинжилгээнд дээж авах <sup>20</sup>                                                      | Өөрчлөлт ороогүй.                                               |
| 6. | Шалгалтын явцад тэмдэглэл хөтлөх                                                                                                                                                                                                                                   | 22.1, 22.1.1, 22.1.2, 22.1.3 | 5.9, 5.10, 5.11 <sup>21</sup>                                                                            | Өөрчлөлт ороогүй.                                               |
| 7. | Шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 өдөр хүртэл байна                                                                                                                                                                                                             | 23.1, 23.2                   | 5 <sup>1</sup> дүгээр зүйл. Төлөвлөгөөт хяналт шалгалт <sup>22</sup>                                     | Өөрчлөлт ороогүй.                                               |
| 8. | Шалгалт дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор шалгалтын танилцуулга боловсруулах                                                                                                                                                                                    | 24.1                         | 5.16 <sup>23</sup>                                                                                       | Өөрчлөлт ороогүй. Танилцуулга боловсруулах хугацааг тодруулсан. |
| 9. | Шалгуулагч этгээдэд шалгалтын дүнг танилцуулах                                                                                                                                                                                                                     | 24.4                         | Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандарт <sup>24</sup>                                     | Стандартаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгасан. |

<sup>18</sup> ТХШТХ-ийн З<sup>1</sup>.1.2-т ““хяналт шалгалтын арга, хэлбэр” гэж тухайн хяналт шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх, шалгуулагч этгээдийн үйл ажиллагаагаа явуулдаг нутаг дэвсгэр, байр, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд үзлэг хийх, ... үйл ажиллагааг” хэлнэ гэж заасан.

<sup>19</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019.04.23-ны өдрийн А/67 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандартын 7 дугаар зүйлд хяналт шалгалтын аргыг тодорхойлсон бөгөөд үүнд үзлэг, туршилт, хэмжилт, магадлал багтсан болно.

<sup>20</sup> ТХШТХ-ийн 5<sup>5</sup> дугаар зүйлээр шинжилгээнд дээж авах харилцааг зохицуулсан.

<sup>21</sup> ТХШТХ-ийн 5.9-д “Хяналт шалгалтын явцад улсын байцаагч шалгалтын тэмдэглэлийг хоёр хувь үйлдэх бөгөөд нэг хувийг шалгуулагч этгээдэд өгөх ба шалгалтын тэмдэглэлд дараах үндсэн мэдээллийг тусгана: 5.9.1.шалгалтын явц болон шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал; 5.9.2.улсын байцаагчийн санал, дүгнэлт; 5.9.3.шалгуулагч этгээдийн санал, хүсэлт.”; 5.10-т “Шалгуулагч этгээд шалгалтын тэмдэглэлтэй танилцаж гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай шалгалтын тэмдэглэлд тусгана.”; 5.11-т “Улсын байцаагч шалгалтын тэмдэглэл болон үр дүнгийн талаар дээд шатны улсын байцаагчид тухайн шалгалт дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор танилцуулна.” гэж хуульчилсан.

<sup>22</sup> ТХШТХ-ийн 5<sup>1</sup>.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн объект дээр хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 өдрөөс илүүгүй байх бөгөөд үүнд шалгалтын дүнг гаргах хугацаа болон санхүүгийн хяналт шалгалт хамаарахгүй.” гэж заасан.

<sup>23</sup> ТХШТХ-ийн 5.16-д “Хяналт шалгалтын дүнгийн тухай танилцуулга, бусад баримт бичгийг зохих журмын дагуу үйлдэж, хяналт шалгалт хийсэн албан тушаалтан гарын үсэг зурна.” гэж заасан.

<sup>24</sup> Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандартын 14.4-т “Хяналт шалгалтын дүнг шалгуулагч этгээдэд танилцуулна” гэж заасан.

|     |                                                                                                                                                                                                     |                      |                                                                                           |                                                                                                            |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|-------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|
| 10. | Жинхэнэ биелэлтийг тогтоох зорилгоор гүйцэтгэлийн шалгалт явуулж болох                                                                                                                              | 25.1, 25.2, 25.3     | 5 <sup>3</sup> дугаар зүйл.<br>Гүйцэтгэлийн шалгалт <sup>25</sup>                         | Өөрчлөлт ороогүй.                                                                                          |
| 11. | Гүйцэтгэлийн шалгалтыг заавал хэрэгжүүлэх                                                                                                                                                           | 25.4, 25.4.1, 25.4.2 |                                                                                           | Зарчмын өөрчлөлт ороогүй. Гүйцэтгэлийн шалгалт хийгддэг байсан бөгөөд заавал хийгдэх нөхцөлийг тодруулсан. |
| 12. | Бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг хураан авах арга хэмжээ авах                                                                                                                                        | 29.1, 29.1.1, 29.1.2 | Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага <sup>26</sup>                               | Стандартаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгасан.                                            |
| 13. | -Хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэх шийдвэрийн хувийг өгөх;<br>-Үүргээ зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай сануулах;<br>-Хураан авах, битүүмжлэх арга хэмжээ авахдаа тэмдэглэл үйлдэх | 29.4, 29.5, 29.6     |                                                                                           | Шинээр нэмэгдсэн.                                                                                          |
| 14. | Ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг түр зогсоосон тохиолдолд шалгуулагч этгээдэд актыг гардуулах                                                                                            | 30.2                 | 5.12 <sup>27</sup> ,<br>Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлагын 14.5 <sup>28</sup> | Зарчмын өөрчлөлт ороогүй. Иргэний эрхийг хангах чиглэлээр тодруулсан.                                      |
| 15. | Гүйцэтгэлийн шалгалт хийж үйл ажиллагаа, ашиглалтыг сэргээх эсэхийг шийдвэрлэх                                                                                                                      | 30.5                 | 5 <sup>3</sup> дугаар зүйл.<br>Гүйцэтгэлийн шалгалт                                       | Зарчмын өөрчлөлт ороогүй. Иргэний эрхийг хангах чиглэлээр тодруулсан.                                      |

<sup>25</sup> ТХШТХ-ийн 5<sup>3</sup>.1-д “Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хяналт шалгалтын байгууллагаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор явуулна.”, 5<sup>3</sup>.2-т “Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагын хүрээнд хийнэ.”, 5<sup>3</sup>.3-т “Гүйцэтгэлийн шалгалт хийхдээ шалгуулагч этгээдэд ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.” гэж хуульчилсан.

<sup>26</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019.04.23-ны өдрийн А/67 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага”-ын 16.3-т “Акт, албан шаардлага, дүгнэлт, улсын ерөнхий байцаагчийн болон ахлах байцаагчийн шийдвэр, барааг буцаах мэдэгдэл, барааг хураах, устгах тухай акт нь Захиргааны ерөнхий хуулийн 40.2-т заасан шаардлагыг хангасан байна”, 16.7-д “Шалгалтын тэмдэглэл, улсын байцаагчийн акт, албан шаардлага, дүгнэлт, барааг түр саатуулах, буцаах тухай мэдэгдэл, барааг хураах, устгах тухай актыг шалгуулагч этгээдэд танилцуулж гарын үсэг зуруулна. Хэрэв хяналт шалгалтын баримт бичигт гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбарыг бичүүлнэ. Тайлбар бичихээс татгалзвал улсын байцаагч тайлбар бичнэ”, уг стандартын норматив хавсралтаар хяналт шалгалтын баримт бичгийн бүтцийн шалгуурыг тогтоосон бөгөөд “О”-д “Бараа хураах, устгах тухай акт”-ын бүтцийг тусгажээ.

<sup>27</sup> ТХШТХ-ийн 5.12-т “Шалгалтын үр дүнд илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох зорилгоор улсын байцаагч тухайн шалгуулагч этгээдийн үйл ажиллагааг түр зогсоосон, эд хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд дээд шатны улсын байцаагч ажлын 5 өдрийн дотор улсын байцаагчийн авсан арга хэмжээг хянан үзэж түүнийг өөрчлөх эсэх асуудлаар шийдвэр гаргаж, шалгуулагч этгээдэд албан ёсоор бичгээр мэдэгдэнэ.” гэжээ.

<sup>28</sup> Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандартын 14.5-д “Улсын байцаагч, хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч хяналт шалгалт хийсэн тухай бүр түүний үр дүнгийн талаар нэгжийн удирдлагад, шаардлагатай бол удирдамж баталсан албан тушаалтанд танилцуулна. Шалгуулагч этгээдийн үйл ажиллагааг түр зогсоосон, эд хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд ТХШТХ-ийн 5.12-т заасан арга хэмжээг авна” гэж заасан.

|                                                            |                                                                                                                                                                                         |            |                                                                                                 |                                                                                                                                                                                           |
|------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|-------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 16.                                                        | Төлбөрийн акт тогтоох                                                                                                                                                                   | 31.1       | 10.2.2 <sup>29</sup>                                                                            | Зарчмын өөрчлөлт ороогүй.<br>Улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагчийн хэрэгжүүлдэг эрхийг улсын байцаагчид олгосон, улсын байцаагчаас гаргах шийдвэрийг төлбөрийн акт хэмээн тодруулсан. |
| 17.                                                        | Тухай бүр хяналт шалгалттай холбогдох баримт бичгийг цахим системд бүртгэх хөтлөх                                                                                                       | 47.3       | 5.14 <sup>30</sup>                                                                              | Зарчмын өөрчлөлт ороогүй.<br>Цахим систем хэмээн тодруулсан.                                                                                                                              |
| 18.                                                        | Импортын мэдэгдэл, экспорт, импортын гэрчилгээ, зөвлөмж, мэдэгдэл, дүгнэлт, албан шаардлага, акт болон мэргэжлийн хяналтын байгууллагын үйлдэх бусад баримт бичиг үйлдэж баталгаажуулах | 34.1       | 10.9.11 <sup>31</sup> ,<br>Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандарт <sup>32</sup> | Стандартаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгасан.                                                                                                                           |
| <b>Хэрэгжүүлэх субъект.Мэргэжлийн байгууллага</b>          |                                                                                                                                                                                         |            |                                                                                                 |                                                                                                                                                                                           |
| 19.                                                        | Дүгнэлт гаргах                                                                                                                                                                          | 26.1       | Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандарт <sup>33</sup>                            | Стандартаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгасан.                                                                                                                           |
| 20.                                                        | Лабораторийн буюу магадлан шинжилгээг гүйцэтгэх                                                                                                                                         | 33, 33.2.1 | 10.12.1 <sup>34</sup>                                                                           | Зарчмын өөрчлөлт ороогүй.                                                                                                                                                                 |
| <b>Хэрэгжүүлэх субъект.Мэргэжлийн хяналтын байгууллага</b> |                                                                                                                                                                                         |            |                                                                                                 |                                                                                                                                                                                           |
| 21.                                                        | -Тандалт судалгаа, хяналт шинжилгээ хийх,<br>-Сургалт зохион байгуулах,                                                                                                                 | 43.1.2     | Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага <sup>35</sup>                                     | Стандартаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгасан.                                                                                                                           |

<sup>29</sup> ТХШТХ-ийн 10.12.2-т “Улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх” эрхтэй гэж хуульчилсан.

<sup>30</sup> ТХШТХ-ийн 5.14-т “Хийсэн хяналт шалгалтын талаархи мэдээллийг тухай бүр хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн санд оруулна.” гэж хуульчилсан.

<sup>31</sup> ТХШТХ-ийн 10.9.11-т “улсын байцаагч хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, албан шаардлага, тоо, баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” хэмээн хуульчилсан.

<sup>32</sup> Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандартын 15-д улсын байцаагчийн үйлдэх хяналт шалгалтын баримт бичгийн төрлийг тодорхойлсон бөгөөд удирдамж, мэдэгдэх хуудас, шалгалтын тэмдэглэл, хяналтын хуудас, танилцуулга, акт, албан шаардлага, дүгнэлт, шийдвэр, албан даалгавар, мэдэгдэл, тэмдэглэл, зөвлөмж зэрэг 13 нэр төрлийн баримт бичгийн бүтцийг журамласан.

<sup>33</sup> Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандартын 13.11-т “Хяналт шалгалтын явцад мэргэжлийн байгууллага, шинжээч, шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулж болно.” гэж заасан.

<sup>34</sup> ТХШТХ-ийн 10.12.1-д “Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч холбогдох байгууллагатай тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

<sup>35</sup> Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлагын 8.5-д “Зөвлөн туслах үйлчилгээ”, 9.15-д “Зөвлөн туслах үйлчилгээний удирдамжийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналтын газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын хяналтын хэлтэс, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга батална”, 13.12-т “Улсын байцаагч нь хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцдаа холбогдох хууль

|                                                                |                                                                                                                        |         |                                                                                                                                                             |                                                                                                                             |
|----------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                | -Хяналтын хуудасны хүрээнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх                                                             |         |                                                                                                                                                             |                                                                                                                             |
| 22.                                                            | Хуульд заасны дагуу зөвшөөрөл, гэрчилгээ, мэдэгдэл олгох, дүгнэлт гаргах                                               | 43.1.3. | 10.8 <sup>36</sup> , Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандарт <sup>37</sup>                                                                   | Стандартаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгасан. Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг тодруулсан. |
| 23.                                                            | Эрсдэлийг үнэлэх, шалтгаан, нөхцөлийг тогтоох, эрсдэлийг бууруулах, арилгах арга хэмжээг авах, үр дүнг нийтэд мэдээлэх | 43.1.4. | 5 <sup>4</sup> дүгээр зүйл.Хяналт шалгалтын объектын эрсдэлийн ангилал <sup>38</sup> , Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандарт <sup>39</sup> | Стандартаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгасан.                                                             |
| 24.                                                            | Лабораторийн шинжилгээ хийх                                                                                            | 43.1.6  | 3 <sup>1.1.2</sup> , 5 <sup>5</sup> дугаар зүйл, 10.12.1 <sup>40</sup>                                                                                      | Өөрчлөлт ороогүй.                                                                                                           |
| <b>Хэрэгжүүлэх субъект.Мэргэжлийн хяналтын төв байгууллага</b> |                                                                                                                        |         |                                                                                                                                                             |                                                                                                                             |

тогтоомж, стандартыг сурталчилж, шалгуулагч этгээдийн эрсдэлийн ангиллыг танилцуулж, эрсдэлийг бууруулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө”, 15.16-д ““Зөвлөмж” гэж шалгуулагч этгээдийн үйл ажиллагаа, объект, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг хяналтын хуудсаар үнэлэн эрх зүйн болон мэргэжлийн зөвлөгөө өгсөн тухай баримт бичиг” гэж тусгасан.

<sup>36</sup> ТХШТХ-ийн 10.8-д “Улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь баталсан, уг улсын байцаагчийг томилох эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, түүнчлэн албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.” гэж хуульчилсан.

<sup>37</sup> Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлагын хавсралтын “К”-д “Бараа, тээврийн хэрэгслийг түр саатуулах мэдэгдэл”, “Л”-д “Бараа буцаах мэдэгдэл”, “Н”-д “Хяналт шалгалтад хамруулсан тухай мэдэгдэл”-ийн бүтцийн шаардлагыг тодорхойлсон.

<sup>38</sup> ТХШТХ-ийн 5<sup>4.1</sup>-д “Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болох хор хохирол, үр дагаврыг харгалзан хяналт шалгалтын объектын эрсдэлийг бага, дунд, их хэмжээний гэж ангилна.”, 5<sup>4.2</sup>-т “Энэ хуулийн 5<sup>4.1</sup>-д заасан эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг Засгийн газар тогтооно.”, 5<sup>4.3</sup>-т “Энэ хуулийн 5<sup>4.2</sup>-т заасан шалгуур, үзүүлэлтийг үндэслэн эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалт, шалгалтад хамруулах давтамжийн хугацааг мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хяналтын чиглэл бүрээр батална.” гэжээ.

<sup>39</sup> Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандартын 4.3-т ““Эрсдэл” гэж хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, ажил үйлчилгээний явцад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандарт зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон орчны аюулгүй байдалд учирч болзошгүй сөрөг үр дагавар, түүний үүсэх магадлалыг” гэж, 5.6-д “Хууль тогтоомжид харшлахгүй бол хяналт шалгалтын дүнг шалгуулагч этгээд болон олон нийтэд мэдээлж болно”, 13.4-т “Улсын байцаагч хяналт шалгалтын объектыг хяналтын хуудсаар шалгаж шалгуулагч этгээдийн эрсдэлийн түвшинг тогтооно” гэж тодорхойлсон.

<sup>40</sup> ТХШТХ-ийн 3<sup>1.1.2</sup> “хяналт шалгалтын арга, хэлбэр” гэж тухайн хяналт шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх, шалгуулагч этгээдийн үйл ажиллагаагаа явуулдаг нутаг дэвсгэр, байр, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд үзлэг хийх, бүтээгдэхүүн болон тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны орчноос дээж авч шинжлэх, турших, учирсан хор хохирол болон гаргасан зөрчлийн хоорондох уялдаа холбоог тогтоох зорилгоор шинжилгээ явуулах зэрэг хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагын албан тушаалтан, түүнчлэн хууль тогтоомжид заасан журмын дагуу хяналт шалгалтад татагдан оролцож байгаа шинжээч, шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг”; 5<sup>5</sup> дугаар зүйлээр шинжилгээнд дээж авах, 10.12.1-т “холбогдох байгууллагатай тохиролцон зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх” гэж тус тус хуульчилсан.

|                                                                         |                                                                                                                 |              |                                 |                                                                                  |
|-------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|---------------------------------|----------------------------------------------------------------------------------|
| 25.                                                                     | Хуульд заасан дүрэм, журам, заавар, аргачлал, хяналтын хуудсыг боловсруулж батлах                               | 44.1.3       | 9.3.3 <sup>41</sup>             | Өөрчлөлт ороогүй.                                                                |
| 26.                                                                     | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээлэл, удирдлагын нэгдсэн сан бүрдүүлэх                                            | 44.1.8, 47.1 | 5.14, 9.3.6 <sup>42</sup>       | Өөрчлөлт ороогүй.                                                                |
| 27.                                                                     | Төлөвлөгөөт шалгалтын ерөнхий төлөвлөгөөг өмнөх оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах, нийтэд мэдээлэх | 46.2, 8.1    | 5 <sup>1</sup> .1 <sup>43</sup> | Зарчмын өөрчлөлт ороогүй.<br>Төлөвлөгөөт шалгалтын төлөвлөгөө хэмээн тодотгосон. |
| 28.                                                                     | Тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Засгийн газарт танилцуулах                                             | 54.1         | 9.3.2 <sup>44</sup>             | Зарчмын өөрчлөлт ороогүй.<br>Тайлан танилцуулах хугацааг тодорхой болгосон.      |
| <b>Хэрэгжүүлэх субъект.Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч</b> |                                                                                                                 |              |                                 |                                                                                  |
| 29.                                                                     | Санал, дүгнэлтээ эрх бүхий этгээдэд тавьж шийдвэрлүүлэх                                                         | 33.2.2       | 10.12.3 <sup>45</sup>           | Зарчмын өөрчлөлт ороогүй.                                                        |
| 30.                                                                     | Холбогдох нотлох баримтыг эрх бүхий байгууллагад шилжүүлэн шалгуулах                                            | 33.2.3       | 10.12.4 <sup>46</sup>           | Зарчмын өөрчлөлт ороогүй.                                                        |
| 31.                                                                     | Хяналт шалгалтын удирдамжийг батлах                                                                             | 33.2.4       | 10.12.5 <sup>47</sup>           | Зарчмын өөрчлөлт ороогүй.                                                        |
| 32.                                                                     | Гомдлыг хянан шийдвэрлэх                                                                                        | 33.2.5       | 10.12.16 <sup>48</sup>          | Зарчмын өөрчлөлт ороогүй.                                                        |
| 33.                                                                     | Улсын байцаагчийн шийдвэрийг хянан үзэх                                                                         | 33.2.6       | 10.12.6 <sup>49</sup>           | Зарчмын өөрчлөлт ороогүй.<br>Улсын байцаагчийн шийдвэрийг хянах улсын ерөнхий    |

<sup>41</sup> ТХШТХ-ийн 9.3.3-т “Мэргэжлийн хяналтын төв байгууллага нь хяналтын чиглэл тус бүрээр хяналт шалгалт явуулахтай холбогдсон журам, заавар, маягт, аргачлал, техникийн ерөнхий шаардлага, эрсдэлийн ангиллыг харгалзан хяналт шалгалт хийх стандарт, хяналтын хуудас батлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

<sup>42</sup> ТХШТХ-ийн 5.14-т “Хийсэн хяналт шалгалтын талаархи мэдээллийг тухай бүр хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн санд оруулна.” гэж, 9.3.6-д “Мэргэжлийн хяналтын төв байгууллага нь хяналт шалгалтын бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлж хөтлөх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

<sup>43</sup> ТХШТХ-ийн 5<sup>1</sup>.1-д “Мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагаас дараа жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг эрсдэлийн үнэлгээг харгалзан мэргэжлийн хяналтын төв байгууллага өмнөх жилийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор баталж, олон нийтэд мэдээлнэ.” гэж заасан.

<sup>44</sup> ТХШТХ-ийн 9.3.2-т “Мэргэжлийн хяналтын төв байгууллага нь хууль тогтоомж, түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг хэрэгжүүлж байгаа байдлыг судлан нэгтгэж, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг боловсронгуй болгох саналаа зохих байгууллагад хүргүүлж, жилд нэг удаа Засгийн газарт танилцуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” хэмээн хуульчилсан.

<sup>45</sup> ТХШТХ-ийн 10.12.3-т “Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч энэ хуулийн 10.9.7-д заасан шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол улсын байцаагчийн шийдвэрийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, эсхүл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

<sup>46</sup> ТХШТХ-ийн 10.12.4-т “Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч ноцтой осол аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их хэмжээний хор хохирол учирсан тохиолдолд болон илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

<sup>47</sup> ТХШТХ-ийн 10.12.5-д “Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

<sup>48</sup> ТХШТХ-ийн 10.12.16-д “Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч улсын байцаагчийн үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

<sup>49</sup> ТХШТХ-ийн 10.12.6-д “Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч улсын байцаагчийн үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

|                                                                            |                                                                                                |              |     |                                                                                                           |
|----------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------|--------------|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                            |                                                                                                |              |     | байцаагч, улсын ахлах байцаагчийн бүрэн эрхийг “гомдол гаргасан эсэхээс нь үл хамааран” хэмээн өөрчилсөн. |
| 34.                                                                        | Улсын байцаагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд хяналт тавих                                 | 33.2.7       | --- | Шинээр нэмэгдсэн.                                                                                         |
| <b>Хэрэгжүүлэх субъект.Улсын байцаагчийн эрхтэй бусад этгээд</b>           |                                                                                                |              |     |                                                                                                           |
| 35.                                                                        | Улсын ерөнхий байцаагчтай гэрээ байгуулах                                                      | 33.7, 33.7.1 | --- | Шинээр нэмэгдсэн. Улсын байцаагчийн эрхтэй бусад этгээдийн харилцааг тодруулсан.                          |
| 36.                                                                        | Мэргэжлийн хяналтын төв байгууллагатай урьдчилан зөвшилцөж, оны эхний 01 дүгээр сард батлуулах | 33.7.2       | --- | Шинээр нэмэгдсэн. Улсын байцаагчийн эрхтэй бусад этгээдийн харилцааг тодруулсан.                          |
| 37.                                                                        | Шалгалтын дүн, тайлангаа тухай бүр мэргэжлийн хяналтын төв байгууллагад хүргүүлэх              | 33.7.3       | --- | Шинээр нэмэгдсэн. Улсын байцаагчийн эрхтэй бусад этгээдийн харилцааг тодруулсан.                          |
| <b>Хэрэгжүүлэх субъект.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага</b>           |                                                                                                |              |     |                                                                                                           |
| 38.                                                                        | Улсын байцаагчаас тогтоосон төлбөрийн актыг албадан гүйцэтгэх                                  | 36.2         | --- | Шинээр нэмэгдсэн. Улсын байцаагчийн шийдвэрийг биелүүлэх зохицуулалтыг баталгаажуулсан.                   |
| <b>Хэрэгжүүлэх субъект.Яам, агентлаг</b>                                   |                                                                                                |              |     |                                                                                                           |
| 39.                                                                        | Санал, зөвлөмжийн хариуг тогтоосон хугацаанд өгөх                                              | 55.3         | --- | Шинээр нэмэгдсэн. Мэргэжлийн хяналтын төв байгууллагын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулсан.             |
| <b>Хэрэгжүүлэх субъект.Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан</b> |                                                                                                |              |     |                                                                                                           |
| 40.                                                                        | Санал, зөвлөмжийн хариуг тогтоосон хугацаанд өгөх                                              | 56.6         | --- | Шинээр нэмэгдсэн. Мэргэжлийн хяналтын байгууллагын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулсан.                 |

Дээр дурдсан 40 үүргээс 23-т нь өөрчлөлт, эсхүл зарчмын шинжтэй өөрчлөлт ороогүй; 9 нь стандартаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгасан; 8 нь шинээр нэмэгдсэн үүрэг байна. Шинээр нэмэгдсэн 8 үүрэг нь бүгд хяналт шалгалтын дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа, төрийн байгууллагын хоорондын харилцааг зохицуулсан болно.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн хяналт шалгалтын тухай хууль, стандартаар нэгэнт хийгддэг үүрэг нь төрийн байгууллагад шинээр бий болгосон үүрэг бус тул стандарт ажиллагааг тодорхойлох шаардлагагүй бөгөөд нэмэлт зардал шаардахгүй болно.

### 3.2. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр шинээр нэмэгдсэн төрийн байгууллагын үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох ажиллагааг дараах гурван алхмаар гүйцэтгэдэг:

- зарцуулах хугацааг тодорхойлох;
- тохиолдлын тоог тодорхойлох;
- шаардагдах нийт ажлын цагийг тогтоох.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд стандартаар зохицуулан хийж байсан үүргийг нэмж тусгасан бөгөөд мэргэжлийн хяналтын байгууллагад шинээр үүрэг хүлээлгээгүй тул тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох шаардлагагүй болно.

### 3.3. Гарах зардлыг тооцох

Төрийн захиргааны байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал (төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал);
- Материаллаг зардал (төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал);
- Бусад зардал (тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал)-ыг тооцож гаргана.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн ажиллах нөхцөл, баталгааны талаар тусгагдсан зохицуулалтыг авч үзье.

| Д/д | Хуулийн төслийн зохицуулалт                                                                                                                                                                                                                                                                                  |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1.  | 53.1.2.улсын байцаагчийн хилийн боомтод ажилласан нэг жилийг нэг жил гурав сар ажилласанд тооцох ба хилийн боомт, аймаг, суманд таваас доошгүй жил ажиллаж байгаа улсын байцаагчид ажилласан таван жил тутам 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох;                              |
| 2.  | 53.1.3.хилийн боомтод ажиллаж байгаа улсын байцаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон өндөр насны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төр хариуцах; |
| 3.  | 53.1.4.улсын байцаагчийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгах бөгөөд даатгалын төлбөрийг тухайн байгууллагын төсвөөс төлөх;                                                                                                                                                                                 |
| 4.  | 53.1.5.хилийн боомтод ажиллаж байгаа улсын байцаагчид албан тушаалын үндсэн цалингийн 32 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлсийг сар тутам олгох;                                                                                                                                                          |
| 5.  | 53.1.6.голомтын бүсэд ажилласан улсын байцаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгох;                                                                                                                                                                                    |
| 6.  | 53.1.7.албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас, багаж, техник хэрэгслээр хангагдах.                                                                                                                                                                                                 |
| 7.  | 53.2.Энэ хуулийн 53.1.2, 53.1.3, 53.1.5, 53.1.7-д заасан нэмэгдэл баталгаа хилийн боомтод ажиллаж байгаа мэргэжлийн хяналтын байгууллагын бусад албан хаагчид нэгэн адил үйлчилнэ.                                                                                                                           |
| 8.  | 53.3.Улсын байцаагч мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгана.                                                                 |
| 9.  | 53.4.Улсын байцаагч цар тахал, хүний амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.                                   |

|     |                                                                                                                                                                                      |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 10. | 53.5.Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс мэргэжлийн хяналтын төв байгууллагын улсын байцаагчтай ижил байна. |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Дээр дурдсан мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн ажиллах нөхцөл, баталгаг хангахад хүний нөөцтэй холбогдон гарах зардлыг урьдчилсан байдлаар тооцё.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн төслийн 53.1.2-т “... хилийн боомт, аймаг, суманд таваас доошгүй жил ажиллаж байгаа улсын байцаагчид ажилласан таван жил тутам 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох;” гэж заасан. Энд үүсэх хүний нөөцийн зардлыг тооцохын тулд аймаг, суманд ажиллаж байгаа улсын байцаагч, хилийн боомтод ажиллаж байгаа нийт албан хаагчдын тоог гаргана. Учир нь хуулийн төслийн 53.2-т “Энэ хуулийн 53.1.2, 53.1.3, 53.1.5, 53.1.7-д заасан нэмэгдэл баталгаа хилийн боомтод ажиллаж байгаа мэргэжлийн хяналтын байгууллагын бусад албан хаагчид нэгэн адил үйлчилнэ.” хэмээн заасан.

32

| Д/д | Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага | Улсын байцаагчийн нийт тоо | Таваас доошгүй жил ажилласан | Д/д | Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага | Улсын байцаагчийн нийт тоо | Таваас доошгүй жил ажилласан |
|-----|----------------------------------------------|----------------------------|------------------------------|-----|----------------------------------------------|----------------------------|------------------------------|
| 1.  | Архангай                                     | 25                         | 4                            | 12. | Орхон                                        | 28                         | 2                            |
| 2.  | Баян-Өлгий                                   | 38                         | 9                            | 13. | Өвөрхангай                                   | 22                         | 9                            |
| 3.  | Баянхонгор                                   | 21                         | 3                            | 14. | Өмнөговь                                     | 55                         | 17                           |
| 4.  | Булган                                       | 16                         | 9                            | 15. | Сүхбаатар                                    | 25                         | 10                           |
| 5.  | Говь-Алтай                                   | 31                         | 15                           | 16. | Сэлэнгэ                                      | 24                         | 12                           |
| 6.  | Говьсүмбэр                                   | 12                         | 3                            | 17. | Төв                                          | 22                         | 6                            |
| 7.  | Дархан-Уул                                   | 26                         | 4                            | 18. | Увс                                          | 33                         | 19                           |
| 8.  | Дорноговь                                    | 24                         | 6                            | 19. | Ховд                                         | 38                         | 13                           |
| 9.  | Дорнод                                       | 44                         | 5                            | 20. | Хөвсгөл                                      | 28                         | 13                           |
| 10. | Дундговь                                     | 15                         | 7                            | 21. | Хэнтий                                       | 20                         | 8                            |
| 11. | Завхан                                       | 28                         | 3                            | 22. | <b>ДҮН</b>                                   | <b>575</b>                 | <b>177</b>                   |

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хүний нөөцийн 2021 оны мэдээллийг судалж үзэхэд 21 аймаг, суманд нийт 575 улсын байцаагч ажиллаж байгаагаас 177 нь таваас доошгүй жил ажилласан байна.

Хилийн боомтод ажиллаж байгаа улсын байцаагч болон таваас доошгүй жил ажиллаж байгаа албан хаагчдын тоог гаргая.

| Д/д | Хилийн мэргэжлийн хяналтын байгууллага | Нийт албан хаагчийн тоо |
|-----|----------------------------------------|-------------------------|
| 1.  | Замын-Үүд боомт дахь ХМХА              | 101                     |
| 2.  | Буянт-Ухаа боомт дахь ХМХА             | 124                     |
| 3.  | Сүхбаатар боомт дахь ХМХА              | 73                      |
| 4.  | <b>Нийт</b>                            | <b>298</b>              |

Албан хаагч бүрийн үндсэн цалингийн хэмжээ ялгаатай тул төрийн албан хаагчийн цалингийн шатлалд үндэслэн дунджаар нь тооцё.



| Цалингийн<br>шатлал <sup>50</sup> | Албан тушаалын зэрэглэл <sup>51</sup> |                |
|-----------------------------------|---------------------------------------|----------------|
|                                   | ТЗ-6                                  | ТЗ-7           |
| 1                                 | 690,018                               | 744,765        |
| 2                                 | 731,527                               | 790,426        |
| 3                                 | 773,046                               | 836,096        |
| 4                                 | 813,215                               | 880,281        |
| 5                                 | 853,375                               | 924,456        |
| <b>Дундаж</b>                     | <b>772,236</b>                        | <b>835,204</b> |

Мөнгөн урамшуулалд хамрагдах боломжтой албан хаагчийн үндсэн цалингийн хэмжээг тодорхойлохын тулд “ТЗ-6”, “ТЗ-7” зэрэглэлийн дундаж цалинг дахин дундажлахад 803,720 төгрөг гарч байна.

$$(772,236 + 835,204 = 1,607,441 / 2 = 803,720)$$

Таваас доошгүй жил ажиллаж байгаа улсын байцаагчид ажилласан таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоход гарах зардлыг урьдчилан тооцё.

| Д/д | Орон нутаг,<br>хилийн<br>мэргэжлийн<br>хяналтын<br>байгууллага | Нэг албан<br>хаагчийн<br>үндсэн<br>цалингийн<br>дундаж<br>хэмжээ | 12 сарын<br>цалинтай<br>тэнцэх<br>хэмжээний<br>мөнгөн<br>урамшуулал | Мөнгөн<br>урамшуулалд<br>хамрагдах<br>албан<br>хаагчийн тоо | Мөнгөн<br>урамшууллын<br>нийт дүн |
|-----|----------------------------------------------------------------|------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|-----------------------------------|
|     |                                                                | (төгрөг)                                                         |                                                                     |                                                             | (төгрөг)                          |
| 1.  | 21 аймгийн МХГ                                                 | 803,720                                                          | 9,644,640                                                           | 177                                                         | 1,707,101,280                     |
| 2.  | 3 боомт дахь ХМХА                                              | 803,720                                                          | 9,644,640                                                           | 298                                                         | 2,874,102,720                     |
| 3.  | Нийт                                                           |                                                                  |                                                                     | 475                                                         | 4,581,204,000                     |

*Орон нутаг, хилийн мэргэжлийн хяналтын байгууллагад таваас доошгүй ажил ажиллаж байгаа албан хаагчид нэг жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоход нэг албан хаагчид 9.6 сая төгрөг олгогдох бөгөөд 475 орчим албан хаагчид 4.5 тэрбум гаруй төгрөгийн урамшуулал олгогдоно.*

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 53.1.3-т “хилийн боомтод ажиллаж байгаа улсын байцаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон өндөр насны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төр хариуцах;”, 53.2-т “Энэ хуулийн 53.1.2, 53.1.3, 53.1.5, 53.1.7-д заасан нэмэгдэл баталгаа хилийн боомтод ажиллаж байгаа мэргэжлийн хяналтын байгууллагын бусад албан хаагчид нэгэн адил үйлчилнэ.” хэмээн заасан. Эрүүл мэндийн болон өндөр насны тэтгэврийн даатгалын шимтгэлийг одоо мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож төр хариуцахад гарах зардлыг тооцё.

<sup>50</sup> Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-нд үндэслэн тооцов.

<sup>51</sup> Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-д зааснаар нутгийн захиргааны байгууллагын “Улсын ахлах байцаагч” нь “ТЗ-7”, “Улсын байцаагч” нь “ТЗ-6” зэрэглэлд хамаарч байна

Замын-Үүд, Буянт-Ухаа, Сүхбаатар боомт дахь ХМХА-нд нийт 298 албан хаагч ажиллаж байгааг өмнөх хүснэгтэд тооцоолсон.

| Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ <sup>52</sup><br>(төгрөг) | ЭМД-ын шимтгэлийн хувь хэмжээ | ЭМД-ын даатгалын шимтгэл<br>(төгрөг) | НД-ын шимтгэлийн хувь хэмжээ | НД-ын шимтгэл | Нийт шимтгэлийн хэмжээ<br>(төгрөг) | Нэг жилийн шимтгэл |
|-----------------------------------------------------------|-------------------------------|--------------------------------------|------------------------------|---------------|------------------------------------|--------------------|
| 420,000                                                   | 2                             | 8400                                 | 12.5                         | 52500         | 60900                              | 730,800            |

34

Хилийн мэргэжлийн хяналтын албанд ажиллаж байгаа нэг албан хаагчийн гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон төр хариуцахад нэг жилд 730 мянган төгрөгийн нэмэлт зардал гарахаар байна. Үүнийг нийт албан хаагчийн тоогоор харьцуулья.

$$298/2 * 730,800 \text{ төгрөг} = 108,889,200 \text{ төгрөг.}$$

*Хилийн мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчдын гэр бүлийн тал хувийг нь ажлаар хангаагүй хэмээн үзэхэд тэдний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцахад нэг жилд дунджаар 108 орчим сая төгрөгийн зардал гарна.*

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 53.1.4-т “улсын байцаагчийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгах бөгөөд даатгалын төлбөрийг тухайн байгууллагын төсвөөс төлөх” хэмээн тусгажээ. Даатгалын төлбөрийн зардлыг урьдчилсан байдлаар тооцъё. Мэргэжлийн хяналтын байгууллагын системийн хэмжээнд 2200 ажилтан, албан хаагчид ажилладаг бөгөөд үүнээс 1266 нь төрийн захиргааны албан тушаал хашидаг буюу улсын байцаагчид байна.<sup>53</sup> Монгол Улсад хүний амь нас, эрүүл мэндийн даатгал “сайн” хөгжөөгүй бөгөөд даатгалын үнэлгээг тогтоох нь суурь нөхцөл болдог. Даатгуулагчийн сонгосон даатгалын үнэлгээнээс гадна даатгуулагчийн нас, хүйс, даатгалын гэрээний хугацаа, төлбөр төлөх хугацаа зэргээс хамааран даатгалын хураамжийн хэмжээ ялгаатай байдаг. Даатгалын төлбөрийг урьдчилсан байдлаар тооцохын тулд “Үндэсний амьдралын даатгал” компанийн даатгалын хураамжийн тооцоолуурыг ашиглалаа.<sup>54</sup>

| Даатгалын үнэлгээ | Нас | Хүйс | Гэрээний хугацаа | Хураамж төлөх давтамж | Хураамжийн хэмжээ<br>(төгрөг) | Жилд төлөх хураамжийн хэмжээ |
|-------------------|-----|------|------------------|-----------------------|-------------------------------|------------------------------|
| 10,000,000        | 35  | эр   | 1 жил            | Улирал бүр            | 9476                          | 113,712                      |

Даатгалын үнэлгээг 10 сая төгрөгөөр тогтооход жилд дунджаар 113 мянган төгрөг төлөхөөр байна. Үүнийг нийт улсын байцаагчийн тоонд харьцуулан үзье.

$$1266 * 113,712 \text{ төгрөг} = 143,959,392$$

*Мэргэжлийн хяналтын байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа нийт улсын байцаагч буюу 1266 албан хаагчийг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулан,*

<sup>52</sup> Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 05 дугаар тогтоолоор 2020.01.01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 420 мянган төгрөг байхаар шинэчилсэн.

<sup>53</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хүний нөөцийн 2021 оны судалгаанаас авав.

<sup>54</sup> “Үндэсний амьдралын даатгал” компанийн цахим хуудас, <https://www.nlic.mn/aminas>

даатгалын хураамжийг байгууллагаас хариуцахад нэг жилд 143.9 сая төгрөгийн зардал гарна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 53.1.5-д “хилийн боомтод ажиллаж байгаа улсын байцаагчид албан тушаалын үндсэн цалингийн 32 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлсийг сар тутам олгох”; 53.2-т “Энэ хуулийн 53.1.2, 53.1.3, 53.1.5, 53.1.7-д заасан нэмэгдэл баталгаа хилийн боомтод ажиллаж байгаа мэргэжлийн хяналтын байгууллагын бусад албан хаагчид нэгэн адил үйлчилнэ.” гэж тусгажээ. Хилийн боомтын нийт албан хаагчид (өмнөх тооцоонд гарснаар 298 албан хаагч) 32 хувийн нэмэгдэл хөлс сар тутам олгоход гарах зардлыг тооцё.

35

| ХМХА-ны<br>албан<br>хаагчдын тоо | Албан тушаалын<br>үндсэн цалингийн<br>дундаж хэмжээ | 32 хувийн<br>нэмэгдэл<br>хөлсний хэмжээ | Нэг жилд<br>гарах<br>нэмэгдэл<br>хөлсний дүн | Нэмэгдэл<br>хөлсөнд<br>зарцуулагдах<br>нийт дүн |
|----------------------------------|-----------------------------------------------------|-----------------------------------------|----------------------------------------------|-------------------------------------------------|
| (төгрөг)                         |                                                     |                                         |                                              |                                                 |
| 298                              | 803,720                                             | 257,190                                 | 3,086,285                                    | 919,712,870                                     |

Албан тушаалын үндсэн цалингийн 32 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс сар тутам олгоход нэг албан хаагч жилд 3 сая гаруй төгрөгийн нэмэгдэл хөлс авах бөгөөд 298 албан хаагчид уг нэмэгдэл хөлсийг нэг жилийн хугацаанд олгоход төрөөс 919 сая төгрөгийн зардал шаардлагатай.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 53.1.6-д “голомтын бүсэд ажилласан улсын байцаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгох”; 53.1.7-д “албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас, багаж, техник хэрэгслээр хангагдах.” хэмээн тусгажээ. Голомтын бүсэд ажилласан албан томилолт болон хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслийн зардал нь хүний нөөцийн зардалд хамаарахгүй, нөгөө талаас эдгээр зардлыг тооцох аргачлал, норматив гараагүй, тохиолдлын тоо тодорхой бус болно. Иймд хуулийн төслийн 53.1.6, 53.1.7-д заасан албан томилолт, хөдөлмөр хамгааллын зардлыг тооцох шаардлагагүй байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 53.3-т “улсын байцаагч мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгана.”, 53.4-т “Улсын байцаагч цар тахал, хүний амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” хэмээн заасан. Мэргэшлийн зэргийн нэмэгдэл, өндөр эрсдэлтэй нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэвэл олгох мөнгөн урамшуулал нь хүний нөөцийн зардалд хамаарах хэдий ч энэ харилцааг Засгийн газар, Засгийн газрын гишүүд хамтран батлахаар хуулийн төсөлд тусгасан байна. Иймд эдгээр зардлыг тооцох боломжгүй болно.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 53.5-д “Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс мэргэжлийн хяналтын төв байгууллагын улсын байцаагчтай ижил байна” хэмээн тусгажээ. Энэ зохицуулалтыг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцё.

Төрийн албаны тухай хуулийн 10.4, 18.8 дахь хэсгийг<sup>55</sup> тус тус үндэслэн Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт” батлагдсан.<sup>56</sup> “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-д зааснаар Засгийн газрын агентлагийн “Улсын ахлах байцаагч” нь төрийн захиргааны ахлах түшмэл ангиллын “ТЗ-8”, “Улсын байцаагч” нь төрийн захиргааны дэс түшмэл ангиллын “ТЗ-7” зэрэглэлд; нутгийн захиргааны байгууллагын “Улсын ахлах байцаагч” нь төрийн захиргааны дэс түшмэл ангиллын “ТЗ-7”, “Улсын байцаагч” нь төрийн захиргааны дэс түшмэл ангиллын “ТЗ-6” зэрэглэлд хамаарч байна.

| Д/д | Байгууллага                    | Албан тушаал         |                                |          | Хуулийн төсөлд тусгасан байдал |
|-----|--------------------------------|----------------------|--------------------------------|----------|--------------------------------|
|     |                                | Нэр                  | Ангилал                        | Зэрэглэл |                                |
| 1.  | Засгийн газрын агентлаг        | Улсын ахлах байцаагч | Төрийн захиргааны ахлах түшмэл | ТЗ-8     | Хэвээр                         |
|     |                                | Улсын байцаагч       | Төрийн захиргааны дэс түшмэл   | ТЗ-7     | Хэвээр                         |
| 2.  | Нутгийн захиргааны байгууллага | Улсын ахлах байцаагч | Төрийн захиргааны дэс түшмэл   | ТЗ-7     | ТЗ-8                           |
|     |                                | Улсын байцаагч       | Төрийн захиргааны дэс түшмэл   | ТЗ-6     | ТЗ-7                           |

Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад ажиллаж байгаа улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн тоог Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын судалгаанд үндэслэн тооцов. Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага гэдэгт Нийслэл хот, дүүргээс бусад газарт үйл ажиллагаагаа явуулж байгаа мэргэжлийн хяналтын байгууллага буюу 21 аймаг дахь Мэргэжлийн хяналтын газар, Замын-Үүд болон Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албыг оруулан тооцов.<sup>57</sup>

| Д/д | Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллага | Улсын ахлах байцаагчийн тоо /ТЗ-7/ | Улсын байцаагчийн тоо /ТЗ-6/ |
|-----|----------------------------------------------|------------------------------------|------------------------------|
| 1.  | Архангай                                     | 3                                  | 22                           |
| 2.  | Баян-Өлгий                                   | 7                                  | 31                           |
| 3.  | Баянхонгор                                   | 3                                  | 18                           |
| 4.  | Булган                                       | 2                                  | 14                           |
| 5.  | Говь-Алтай                                   | 4                                  | 27                           |
| 6.  | Говьсүмбэр                                   | 2                                  | 10                           |
| 7.  | Дархан-Уул                                   | 4                                  | 22                           |
| 8.  | Дорноговь                                    | 2                                  | 22                           |
| 9.  | Дорнод                                       | 3                                  | 41                           |
| 10. | Дундговь                                     | 5                                  | 10                           |
| 11. | Завхан                                       | 4                                  | 24                           |
| 12. | Орхон                                        | 3                                  | 25                           |
| 13. | Өвөрхангай                                   | 3                                  | 19                           |
| 14. | Өмнөговь                                     | 5                                  | 50                           |
| 15. | Сүхбаатар                                    | 3                                  | 22                           |

<sup>55</sup> Төрийн албаны тухай хуулийн 10.4-т “Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын төрөлд хамаарах албан тушаалын жагсаалтыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэж, 18.8-д “Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэж хуульчилсан.

<sup>56</sup> Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail/14568>

<sup>57</sup> Энд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албыг тус тус тооцоогүй болно.

|     |                      |           |            |
|-----|----------------------|-----------|------------|
| 16. | Сэлэнгэ              | 4         | 20         |
| 17. | Төв                  | 2         | 20         |
| 18. | Увс                  | 2         | 31         |
| 19. | Ховд                 | 4         | 34         |
| 20. | Хөвсгөл              | 2         | 26         |
| 21. | Хэнтий               | 3         | 17         |
| 22. | Замын-Үүд боомт ХМХА | 8         | 54         |
| 23. | Сүхбаатар боомт ХМХА | 6         | 33         |
| 24. | <b>ДҮН</b>           | <b>84</b> | <b>592</b> |

Орон нутагт 84 улсын ахлах байцаагч, 592 улсын байцаагч ажиллаж байна.<sup>58</sup> Орон нутагт ажиллаж байгаа улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн ангилал, зэрэглэлийг мэргэжлийн хяналтын төв байгууллагын улсын байцаагчтай ижил болгоход гарах зардлыг тооцож үзье.

| Д/д                            | Албан тушаалын зэрэглэл |         | Цалингийн зөрүү | Албан тушаалын зэрэглэл |           | Цалингийн зөрүү |
|--------------------------------|-------------------------|---------|-----------------|-------------------------|-----------|-----------------|
| Цалингийн шатлал <sup>59</sup> | ТЗ-6                    | ТЗ-7    |                 | ТЗ-7                    | ТЗ-8      |                 |
|                                | (төгрөг)                |         |                 |                         |           |                 |
| 1                              | 690,018                 | 744,765 | 54,687          | 744,765                 | 804,986   | 60,221          |
| 2                              | 731,527                 | 790,426 | 58,899          | 790,426                 | 855,213   | 64,787          |
| 3                              | 773,046                 | 836,096 | 63,050          | 836,096                 | 905,451   | 69,355          |
| 4                              | 813,215                 | 880,281 | 67,066          | 880,281                 | 954,054   | 73,773          |
| 5                              | 853,375                 | 924,456 | 71,081          | 924,456                 | 1,002,648 | 78,192          |
|                                | Дундаж                  |         | 62,956.6        | Дундаж                  |           | 69,265.6        |

Төрийн захиргааны албан тушаалын “ТЗ-6” зэрэглэлээс “ТЗ-7” зэрэглэлд шилжихэд дунджаар 63 мянган, “ТЗ-7” зэрэглэлээс “ТЗ-8” зэрэглэлд шилжихэд дунджаар 69 мянган төгрөгийн зөрүү үүсэхээр байна. Энэ зөрүүг орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад улсын ахлах байцаагч, улсын байцаагчаар ажиллаж байгаа хүний тоонд харьцуулан үзье.

| Д/д         | Улсын байцаагчийн тоо | Цалингийн зөрүү | Дүн                 |
|-------------|-----------------------|-----------------|---------------------|
|             |                       | (төгрөг)        |                     |
| “ТЗ-7”      | 84                    | 62,956.6        | 5,288,354.4         |
| “ТЗ-8”      | 592                   | 69,265.6        | 41,005,235.2        |
| <b>Бүгд</b> | <b>676</b>            |                 | <b>46,293,589.6</b> |

Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт орсноор орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад ажиллаж байгаа 676 албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинд 46.2 сая төгрөг шаардлагатай болно.

Дээр дурдсан үндсэн цалингаас төрийн захиргааны албан хаагчид олгох төрийн алба хаасан хугацааны болон төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг тооцъё.

| Нэмэгдэл | Хувь | Улсын ахлах байцаагчийн цалингийн зөрүү | Улсын байцаагчийн цалингийн зөрүү |
|----------|------|-----------------------------------------|-----------------------------------|
|----------|------|-----------------------------------------|-----------------------------------|

<sup>58</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хүний нөөцийн 2021 оны судалгаанаас авав.

<sup>59</sup> Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-нд үндэслэн тооцов.

|                                                                      |    |               |               |
|----------------------------------------------------------------------|----|---------------|---------------|
| Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл <sup>60</sup>                  |    | <b>69,266</b> | <b>62,957</b> |
|                                                                      | 5  | 3463          | 3118          |
|                                                                      | 10 | 6927          | 6296          |
|                                                                      | 15 | 10390         | 9444          |
|                                                                      | 20 | 13853         | 12591         |
|                                                                      | 25 | 17316         | 15739         |
| <b>Дундаж</b>                                                        |    | <b>10390</b>  | <b>9438</b>   |
| Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл <sup>61</sup> |    |               |               |
| Ахлах түшмэл                                                         | 32 | 22165         | 20146         |
|                                                                      | 30 | 20780         | 18887         |
|                                                                      | 28 | 19394         | 17628         |
|                                                                      | 26 | 18009         | 16369         |
| <b>Дундаж</b>                                                        |    | <b>20079</b>  | <b>18257</b>  |
| Дэс түшмэл                                                           | 24 | 16624         | 15110         |
|                                                                      | 22 | 15239         | 13851         |
|                                                                      | 20 | 13853         | 12591         |
|                                                                      | 18 | 12468         | 11332         |
| <b>Дундаж</b>                                                        |    | <b>14546</b>  | <b>13221</b>  |

Улсын ахлах байцаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл төрийн албанд ажилласан хугацаанаас хамааран 3463 төгрөгөөс 17316 төгрөг хүртэл буюу дунджаар 10390 төгрөгөөр, улсын байцаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 3118 төгрөгөөс 15739 төгрөг хүртэл буюу дунджаар 9438 төгрөгөөр нэмэгдэхээр байна. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл улсын ахлах байцаагчийн хувьд ахлах түшмэлийн зэрэгтэй бол 18009 төгрөгөөс 22165 хүртэл төгрөг буюу дунджаар 20079 төгрөгөөр, дэс түшмэлийн зэрэгтэй бол 12468 төгрөгөөс 16624 төгрөг хүртэл буюу дунджаар 14546 төгрөгөөр; улсын байцаагчийн хувьд ахлах түшмэлийн зэрэгтэй бол 18257 төгрөгөөс 20146 төгрөг хүртэл буюу дунджаар 18257 төгрөгөөр, дэс түшмэлийн зэрэгтэй бол 11332 төгрөгөөс 15110 төгрөг хүртэл буюу дунджаар 13221 төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна.

Улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн албан тушаалын хүний нөөцийн нэмэгдэх зардлыг авч үзье.

| Албан тушаал         | Албан тушаалын зэрэглэл | Үнсэн цалингийн зөрүү <sup>62</sup> | Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн дундаж хэмжээ | Төрийн захиргааны зэрэг дэвийн нэмэгдлийн дундаж хэмжээ | Нэг сарын нэмэгдэх цалин | 12 сарын нэмэгдэх цалин | НДШ     | Нийт нэмэгдэх |
|----------------------|-------------------------|-------------------------------------|-------------------------------------------------------|---------------------------------------------------------|--------------------------|-------------------------|---------|---------------|
| Улсын ахлах байцаагч | ТЗ-8                    | 69265                               | 10390                                                 | 14546                                                   | 94201                    | 1,130,412               | 141,301 | 1,271,713     |

<sup>60</sup> Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-д үндэслэв.

<sup>61</sup> Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасан зэрэг дэвийн нэмэгдлийн хувьд хэмжээг баримтлав.

<sup>62</sup> Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”

|                   |      |       |      |       |       |           |         |           |
|-------------------|------|-------|------|-------|-------|-----------|---------|-----------|
| Улсын<br>байцаагч | ТЗ-7 | 62957 | 9438 | 13221 | 85616 | 1,027,392 | 128,424 | 1,155,816 |
|-------------------|------|-------|------|-------|-------|-----------|---------|-----------|

Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг өсгөх нь хоол унааны хөнгөлөлтийн хэмжээ өөрчлөгдөх үндэслэл болохгүй тул хоол унааны хөнгөлөлт нэмэгдэнэ хэмээн тооцсонгүй.

Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын улсын ахлах байцаагчийн албан тушаалын зэрэглэлийг “ТЗ-7”-аас мэргэжлийн хяналтын төв байгууллагын улсын ахлах байцаагчтай адил буюу “ТЗ-8” зэрэглэлд шилжүүлэхэд нэг албан хаагчид жилд дунджаар 1.2 сая төгрөгийн; улсын байцаагчийн албан тушаалын зэрэглэлийг “ТЗ-6”-аас мэргэжлийн хяналтын төв байгууллагын улсын байцаагчтай адил буюу “ТЗ-7” зэрэглэлд шилжүүлэхэд нэг албан хаагчид жилд дунджаар 1.1 сая төгрөгийн зардал нэмэгдэж гарна.

Төрийн байгууллагын хүний нөөцийн нэмэгдэх зардлыг нийт албан тушаалын тоогоор авч үзье.

|                         | Нэг жилд нэмэгдэх<br>зардлын хэмжээ<br>(төгрөг) | Одоо ажиллаж<br>байгаа улсын<br>байцаагчийн тоо | Дүн<br>(төгрөг)    |
|-------------------------|-------------------------------------------------|-------------------------------------------------|--------------------|
| Улсын ахлах<br>байцаагч | 1,271,713                                       | 84                                              | 106,823,892        |
| Улсын байцаагч          | 1,155,816                                       | 592                                             | 684,243,072        |
| <b>Нийт</b>             |                                                 | 676                                             | <b>791,066,964</b> |

Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад улсын ахлах байцаагч, улсын байцаагчаар ажиллаж байгаа нийт 676 төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг нэг зэрэглэлээр нэмэгдүүлэхэд нэг жилд 791 сая төгрөгийн нэмэлт зардал шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоо гарч байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагын хүний нөөцийн орон тоо системийн хэмжээнд өөрчлөгдөхгүй тул материаллаг болон бусад зардлын хэмжээнд өөрчлөлт орохгүй болно. Иймд материаллаг болон бусад зардлыг тооцох шаардлагагүй хэмээн үзэв.

### 3.4.Нийт зардлын дүнг тооцох

Төрийн байгууллагаас буюу төрд үүсэх хүний нөөцийн нийт зардлыг дээр дурдсан зардлыг нэмж тооцно.

| Хүний нөөцийн зардлын<br>төрөл                                           | Нэг албан<br>хаагчид<br>ногдох<br>дүн | Хамрагдах<br>албан<br>хаагчийн<br>тоо | Дүн                  |
|--------------------------------------------------------------------------|---------------------------------------|---------------------------------------|----------------------|
| 1.Нэг жилийн үндсэн цалинтай тэнцэх<br>хэмжээний мөнгөн урамшуулал       | 9.6 сая                               | 475                                   | 4.5 тэрбум<br>төгрөг |
| 2.Эрүүл мэндийн болон нийгмийн<br>даатгалын шимтгэлийн зардал            | 730 мянга                             | 149                                   | 108 сая              |
| 3.Амь нас, эрүүл мэндийн даатгалын<br>хураамж                            | 113 мянга                             | 1266                                  | 144 сая              |
| 4.Нэмэгдэл хөлс /32 хувь/                                                | 3 сая                                 | 298                                   | 919 сая              |
| 5.Орон нутгийн мэргэжлийн хяналтын<br>байгууллагын улсын ахлах байцаагч, | 1.1-1.2 сая                           | 676                                   | 791 сая              |

|                                                  |  |             |                         |
|--------------------------------------------------|--|-------------|-------------------------|
| улсын байцаагчийн зэрэглэлийг нэмэгдүүлэх зардал |  |             |                         |
| <b>Нийт</b>                                      |  | <b>2864</b> | <b>6,462 сая төгрөг</b> |

Урьдчилсан тооцоогоор Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхэд давхардсан тоогоор 2864 албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад төрөөс 6,462 сая төгрөгийн хүний нөөцийн нэмэлт зардал гарахаар байна.<sup>63</sup>

40

### 3.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Энэ үе шатанд төсвийн зардлыг багасгаж болох эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачааллыг бууруулах боломж байгаа эсэхийг нягтална. Төрийн байгууллагад шинээр үүрэг нэмэгдээгүй тул чиг үүргээ хэрэгжүүлэхэд гарах нэмэлт зардлын асуудал үүсэхгүй. Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагч, албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар шинэлэг зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан тул уг зардлыг өмнөх хэсэгт урьдчилсан байдлаар тооцсон. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа хангагдсанаар төрийн ажил үйлчилгээ иргэдэд тогтвортой, шуурхай, найдвартай хүрэх нөхцөл бүрдэнэ. Тодруулбал: төр иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой болно. Иймд зардлыг бууруулахыг эрмэлзэх нь ирээдүйд үүсэх эрсдэлийг нэмэгдүүлэх, эерэг үр өгөөжтэй харьцуулшгүй сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй.

*Төрийн байгууллагад үүсэх хүний нөөцийн нэмэлт зардлын урьдчилсан тооцоо: 6,462 сая төгрөг, Нэг төрийн албан хаагчид ногдох хэмжээ: 2.2 сая төгрөг.*

### САНАЛ ЗӨВЛӨМЖ

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу зардлын тооцоо хийв. Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад дараах нэмэлт зардал, ачаалал үүсэх урьдчилсан тооцоо гарч байна:

- Нэг хуулийн этгээдэд 291,649 төгрөгийн зардал;
- Нэг иргэнд 410 минут буюу 6.8 цагийн ачаалал, 1000 төгрөгийн зардал;
- Төрд нийт 6,462 сая төгрөгийн зардал.

Хүний эрхийг хангах, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах, хуулийн хэрэгжилтийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах санал зөвлөмжийг танилцуулж байна:

1.Хуулийн этгээдэд үүсэх нэмэлт зардлыг бууруулах: Аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээд дотоод хяналт шалгалт хийх журмыг батлан мөрдүүлэхээр хуулийн төсөлд тусгасныг дахин судлах, дотоод хяналт шалгалт үр өгөөжтэй эсэхийг нягтлах, дотоод хяналт шалгалт шаардлагатай нь тогтоогдсон нөхцөлд журмыг батлан мөрдүүлэх

<sup>63</sup> Хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах програм хангамж, техник технологийн шинэчлэлийн зардал зэрэг бусад зардлыг тооцоогүй болно.



зохицуулалт хуульд тусгахаас аль болох зайлсхийх, дотоод хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаарх зохицуулалтыг хуулийн төсөлд бүрэн хэмжээнд тодорхой тусгах, үүний дараа журам зайлшгүй батлан мөрдүүлэх үүрэг бүхий хуулийн этгээдийг хуулийн төсөлд тодорхойлох. Ингэснээр эрх зүйн мэдлэг, туршлага багатай хуулийн этгээдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах, хуулийг дагаж мөрдөхөд ойлгомжтой хялбар болно;

2.Иргэнд үүсэх нэмэлт зардал, ачааллыг бууруулах: Иргэнд хуулиар нэг л үүрэг хүлээлгэсэн нь улсын байцаагчийн шаардсан баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх юм. Иргэнээс ямар нөхцөлд баримт бичиг, мэдээлэл шаардаж болохыг тодорхой болгох, улмаар шаардах баримт бичиг, мэдээллийн агуулгыг хуульд тусгах нь зүйтэй. Ингэснээр шалгуулагч этгээдээс шаардсан баримт бичиг, мэдээллийг иргэнээс давхар шаардахгүй байх, иргэн хуулиа уншаад ямар баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй болохоо мэдэх эрх хангагдана.

41

3.Төрд үүсэх зардлыг бууруулах: Хяналт шалгалтын байгууллагад хуулиар хүлээлгэсэн бөгөөд улсын байцаагчийн хэрэгжүүлэх эрх, үүргээс бусад үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх. Төрийн бус байгууллага төрийн хяналт шалгалтад зохих хэмжээнд оролцсоноор хяналт шалгалтын үр нөлөө, хүлээн зөвшөөрөлт нэмэгдэх болно.

Хуулийн этгээд, иргэнд үүсэх зардал нь төдийлөн хүндрэл учруулах хэмжээний биш гэж үзэж байна. Түүнчлэн Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн төсөлд улсын байцаагч нь цахим хэлбэрээр баримт бичиг, мэдээлэлтэй танилцах, эрсдэл өндөр нөхцөлд л хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналт тавих талаар тусгасан нь хуулийн этгээд, иргэнд ирэх бэрхшээл, хүндрэлийг бууруулах зорилготой болно.



## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг.Хууль тогтоомж

1.1.Төрийн хяналт шалгалтын тухай хууль;

1.2.Төрийн албаны тухай хууль;

1.3.Хөдөлмөрийн тухай хууль;

1.4.Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”. **42**

Хоёр.Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт

2.1.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”;

2.2.Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”;

2.3.Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”;

2.4.Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”;

2.5.Засгийн газрын 2020.12.09-ний өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”;

2.6.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019.04.23-ны өдрийн А/67 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандарт.

Гурав.Судалгааны тайлан

3.1.Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2021 он;

3.2.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хүний нөөцийн 2021 оны судалгаа.

Дөрөв.Цахим хуудас

4.1.Нээлттэй засаглал, цахим хуудас, олон нийтэд зориулсан хэсэг, <http://unelgee.gov.mn>;

4.2.Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын цахим хуудас, <http://inspection.gov.mn>;

4.3.Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, [www.1212.mn](http://www.1212.mn);

4.4.Татварын ерөнхий газрын цахим хуудас, [www.mta.mn](http://www.mta.mn);

4.5.Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудас, <https://burtgel.gov.mn>;

4.6.Шилэн хяналтын цахим хуудас, <http://khyanalт.gov.mn>;

4.7.“Үндэсний амьдралын даатгал” компанийн цахим хуудас,  
<https://www.nlic.mn/aminas>.

